



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН  
ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2019 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

## НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл

<b>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

#### 1.1.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг боловсруулах, УИХ-д өргөн барих

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3 дахь хэсэгт заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичиж, жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн барьдаг билээ. Комиссын ажлын албаны ажилтнууд Комиссын дарга, гишүүдийн өгсөн чиглэл, удирдлаган дор "Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл"-ийг боловсруулж, 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж, гишүүн Н.Ганбаяр, П.Оюунчимэг нар УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барьж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад мөн хүргүүлсэн юм. Энэ удаагийн илтгэлийг:

1. Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын талаарх бодлого, түүний хэрэгжилт;
2. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал;
3. Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
5. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт;
6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал гэсэн 6 сэдвийн хүрээнд болон илтгэлээр дамжуулан Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулах 25 саналын хамт боловсрууллаа.

#### 1.1.2 Илтгэлийг цахим хуудаст нийтлэх, хэвлүүлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийн эхийг бэлтгэж, “Мөнхийн үсэг” ХХК-д хэвлүүлэв. Илтгэлийг монгол болон англи хэл дээр [www.nhrcom.gov.mn](http://www.nhrcom.gov.mn) цахим хуудаст нийтэлж, төрийн байгууллагуудад албан бичгийн хамт хүргүүлэв.



### 1.1.3 Илтгэлийг англи хэл рүү орчуулах, хэвлүүлэх, олон улсын байгууллагуудад хүргүүлэх

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг англи хэл дээр орчуулан “Соёмбо” хэвлэлийн газарт 500 хувь хэвлүүлэн холбогдох олон улсын байгууллагуудад хүргүүлж, [www.nhrcm.gov.mn](http://www.nhrcm.gov.mn) цахим хуудаст олон нийтэд нээлттэйгээр тавилаа.

## 1.2 Хяналт шалгалт


Хяналт шалгалт 2019	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Хүний эрхийн Үндэсний Комисс 2019 онд хяналт шалгалтын хүрээнд төлөвлөгөөт-48, гомдлын мөрөөр-23, мэдээллийн мөрөөр-24, санамж бичгийн хүрээнд-11, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой-160, нийт 266 хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан байна.

№	Шалгалтын төрөл	Тоо
1	Төлөвлөгөөт	48
2	Гомдлын мөрөөр	23
3	Мэдээллийн мөрөөр	24
4	Санамж бичгийн дагуу	11
5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	160
Бүгд		266

Үүнээс орон нутгийн ажилтнууд төлөвлөгөөт 39, гомдол, мэдээллийн мөрөөр 15 нийт 54 хяналт шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтыг өмнөх онуудтай харьцуулахад дараах үзүүлэлттэй байна.



### **1.2.1 Санамж бичиг байгуулсан байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулах**

Тус ажлын хүрээнд Комисстай Санамж бичиг байгуулсан байгууллагуудын нийт 24 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллав. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Баянхонгор, Өвөрхангай, Дархан, Сэлэнгэ, Орхон, Архангай, Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байр, мөн аймгуудын Цагдаагийн газрын Саатуулах, Баривчлах байранд тус тус хяналт шалгалт хийж, Комиссын гишүүн газар дээр нь үүрэг, чиглэл өгч ажилласан.

- Мөн ЗХЖШ-ын харьяа Дорнод аймаг дахь Зэвсэгт хүчний 327, Сүхбаатар аймаг дахь Зэвсэгт хүчний 338, Өвөрхангай дахь Зэвсэгт хүчний 256 анги, ХХЕГ-ын харьяа Дорнод аймаг дахь Хилийн цэргийн 132 дугаар анги, Өвөрхангай аймгуудад МҮЭХ-той хамтран төрийн болон хувийн хэвшлийн, төрийн өмчит үйлдвэрийн газруудад хяналт шалгалт хийсэн байна.

### **1.2.2 Химийн хорт болон цацраг идэвхит бодисын хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийх**

Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2019 оны 01 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Замын-Үүд сумдад, 2019 оны 2 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Орхон, Булган аймагт ажиллаж, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд энэ үеэр Булган аймгийн Мал эмнэлгийн лабораторт хүний эрхийн ноцтой зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар Мал эмнэлгийн ерөнхий газрын даргад Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлсэн байна.

Дорноговь аймагт ажилласан ажлын дүн болон Булган аймагт ажилласан хяналт шалгалтын дүнг хамтатган Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурлын дарга, Ерөнхий сайдад 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 1/135 дугаар албан бичгээр тус тус албан бичиг хүргүүлсэн. Баянхонгор, Өвөрхангай аймагт Хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулах үеэр тус аймгуудын хэмжээнд хэрэглэгдэж байгаа химийн хорт болон аюултай бодисын хадгалалт хамгаалалтын асуудлаар мэдээлэл цуглуулж тус арга хэмжээний илтгэх хуудаст тэмдэглэлийг оруулсан болно.

Түүнээс гадна Нийслэл болон аймгуудын ус хангамжийн эх үүсвэрийг цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах асуудалд анхаарал хандуулж ажиллах талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд албан бичиг төлөвлөж хүргүүлсэн болно. Орхон аймагт тодорхой объектод хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалттай холбоотой асуудлаар аймгийн удирдлага, холбогдох албан тушаалтныг байлцуулан уулзалт хийж, мэдээлэл гаргуулан авсан. Комиссын даргын зүгээс үлдсэн аймагт хяналт шалгалт хийх шаардлагагүй, оны эцэст албан бичиг явуулж мэдээлэл авах талаар чиглэл өгсөн. Хяналт шалгалтын илтгэх хуудсыг боловсруулан дүнг нэгтгэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 19 дэх илтгэлд тусгахаар ажиллаж байна.

### **1.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх**

Уг ажлын хүрээнд хяналт шалгалт, судалгаа хийж “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл”-д бүлэг болгон оруулсан.

Судалгааны тайланг танилцуулах уулзалтыг 2019 оны 04 дүгээр сард холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан өргөн хүрээтэй зохион байгуулж, хэлэлцүүлэг хийв. Уулзалтад НҮБХАС-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч, Комиссын дарга тэргүүтэй хүмүүс оролцов

#### 1.2.4 Гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх

Тайлант хугацаанд гомдлын мөрөөр 23, мэдээллийн мөрөөр 24 нийт 47 хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

### 1.3 Судалгаа, бодлогын дүн шинжилгээ

1.3.1 Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд дүн шинжилгээ хийж, санал хүргүүлэх, холбогдох ажлын хэсэгт ажиллах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан байнгын хороодоор хэлэлцэх асуудлын хуваарийг Комиссын дарга, гишүүд, АА-ны даргад зохих журмын дагуу танилцуулж, Комиссын илтгэлийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх талаарх мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллав. Комиссын цахим мэдээллийн сангийн хууль тогтоомжид өгсөн санал, судалгаа, шинжилгээ ажил, Комиссын илтгэлээр өгсөн санал зөвлөмжийг тогтмол хөтлөв. Комисс нь 2019 оны 12 сарын байдлаар 16-ны өдрийн байдлаар 10 хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг, журмын төсөлд хүний эрхийн зарчим, хэм хэмжээний дагуу дүн шинжилгээ хийж, саналын томъёоллыг нэгтгэн боловсруулж, нийт 58 саналыг гарган хууль санаачлагчид хүргүүлжээ.

	Санал өгсөн төсөл	Хаана хүргүүлсэн	Албан бичгийн огноо
1	Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл-тусгайлсан саналгүй	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж	2019.01.28. 1/95
2	Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулга	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж	2019.01.11. 1/25
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын тухай хууль-1 санал	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж	2019.03.12. 1/165
4	Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарийг шинэчлэн тогтоох-тусгайлсан саналгүй	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны дарга Т.Гантөмөр	2019.04.17. 4/222
5	МҮЭХ, УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо, ХЭҮК, МХЕГ, ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сан хамтран 2019 оны 4 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хөдөлмөрлөх эрхийн өнөөгийн төлөв байдал-Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл-Зохистой хөдөлмөр” Үндэсний	УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо-ны дарга Д.Оюунхорол УИХ-ын гишүүн, Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн ахлагч Ц.Мөнх-Оргил нарт МҮЭХ-ноос	

	чуулганаас гаргасан санал-47	албан бичгээр хүргүүлсэн	
6	Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдол хянан шийдвэрлэх журмын төсөл-6 төсөл	Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт	2019.05.03. 4/281
7	Тендерт оролцогчдын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журмын төсөл-1 төсөл	Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт	2019.05.23. 4/322
8	Засгийн газрын тогтоолоор батлагдах "Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам"-ын төслүүд-тусгайлсан саналгүй	Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт	2019.06.14. 4/462
9	"Эрх зүйн хөтчийн ажиллах журам", "Эрх зүйн хөтөчтэй байгуулах гэрээний загвар", "Эрх зүйн хөтчийн өдөр тутмын ажлын бүртгэлийн загвар", "Эрх зүйн хөтчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн загвар"-ын төсөл	ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн	2019.06.17 4/468
10	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго (2030)-ын үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох, мэдээллийн эх үүсвэргүй үзүүлэлтийг хэмжих эх үүсвэрийг бүрдүүлэх, тэдгээрийг тооцох аргачлалыг боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгүүдийн боловсруулсан 28 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулсан төсөл-2 санал	Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн	2019.06.25. 4/484

Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, Ш.Раднаасэд нарын санаачилсан Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсгийн гишүүнээр Комисс ажиллаж байна. Ажлын хэсэг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хуралдсан бөгөөд тус хуулийн төсөлд өгөх саналын томъёоллыг боловсруулав. 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн ордонд "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан гарах хуулиудын төслийг УИХ-аар хэлэлцэхээр болсонтой холбогдуулан, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн үндэсний Комиссоос зохион байгуулах нээлттэй хэлэлцүүлэгт оролцов.

<b>1.3.2 Монгол Улс дахь хүний эрхийн боловсрол олгох бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд үнэлгээ хийх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Уг ажлын хүрээнд БСШУСЯ-ны холбогдох ажилтнуудтай уулзалт хийх, тус яамнаас баталсан сургалтын цөм хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, мөн Хүний эрхийн боловсролын шалгуур үзүүлэлтийн талаар гаргасан аргачлалыг орчуулж, судлав. Мөн "Хүний эрхийн боловсрол-2020" олон улсын иргэний нийгмийн эвслээс боловсруулсан хүний эрхийн боловсрол, сургалтын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийх шалгуур үзүүлэлтийг ашиглан Монгол Улсын албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн

байдлыг боловсролын салбарын 20 гаруй хууль тогтоомж, дүрэм журам, хөтөлбөрт шинжилгээ хийн, үнэлгээний илтгэх хуудсыг боловсруулж, танилцуулав.

Уг үнэлгээг Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд тусгаж, УИХ-д өргөн барив.

<b>1.3.3 Агаарын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх</b>	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Төрийн байгууллагуудын вэб сайтад байршуулсан 10 төрлийн судалгаа, мэдээлэл тайлан, төрөөс баталсан бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийв. Мөн иргэний нийгмийн байгууллага болон байгаль орчны иргэний зөвлөл болон холбогдох яам, нийслэлийн төрийн захиргааны байгууллага, нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай уулзаж, мэдээлэл авч дүн шинжилгээнд ашиглав.

Агаарын бохирдлын талаарх 2017, 2018 оны харьцуулсан тоон мэдээлэл, агаарын бохирдлын хүний эрхэд нөлөөлөх байдал, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагаа, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, агаарын бохирдолтой холбоотой олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудаас хийсэн судалгаа шинжилгээ тайлан мэдээлэл зэрэгт үндэслэн дүн шинжилгээ хийж, ҮАБЗ-д цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулан хүргүүлэв.

<b>1.3.4 "Тогтвортой хөгжил, залуучуудын зохистой хөдөлмөр" үндэсний сүлжээний байгууллагуудтай хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр хамтран мэдээлэл цуглуулах, нөлөөллийн ажил зохион байгуулах</b>	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12


2019 оны 01 сарын 31-ний өдөр "Европын холбооны GSP Plus хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнах үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх төсөл (GSP+2 төсөл)"-ийн тайлангийн уулзалтад бэлтгэж буй TV шторкт Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгээ ноос ноолуурын салбар судалгааны тайлангийн талаар мэдээлэл хийх, тус судалгааны тайлангийн цахим хувилбаруудыг шинэчилж, хүргүүлж ажиллав.

2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ОУХБ-аас үндэсний сүлжээ байгууллагуудад зохион байгуулсан ОУХБ-тай байгуулсан гэрээ, түүнийг хэрхэн тайлагнах тухай зааварчилсан уулзалтад оролцож, тухайн үед Комиссын сэтгүүлчдийн клубын сэтгүүлчдийг чадавхижуулах асуудлаар саналаа гарган танилцуулж байсан билээ. Энэ ажил ажил хэрэг болгон GSP+3 төслийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх талаар ОУХБ-аас хариу захидал ирсэн болно. Үүнийг АА-ны дарга АБЛЕ олон нийтэд оруулж танилцуулсан байна. Мөн ОУХБ-аас ХНХЯ, МАОЭНХ, МҮЭХ-ноос тус бүр хоёр хоёр хүн, ХҮЭК, ЖЭҮХ, МХЕГ, ҮСХ-оос тус бүр нэг хүний төлөөлөл бүхий зохистой хөдөлмөрийн техникийн хороог байгуулж, мэдээлэл солилцох, хамтран ажиллахаар болсны дагуу уг ажлын хэсэгт ажиллахаар болов.

<b>1.3.5 Малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах</b>	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

НҮБХАС-ын санхүүжилтээр Малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн хэрэгжилтийн байдалд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлын бэлтгэлийн хүрээнд удирдамж боловсруулах, Хөвсгөл, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгууд дахь орон нутгийн ажилтнуудаар дамжуулан малтай өрх, малчдын тоо, хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүдийн тоон мэдээлэл зэргийн Статистикийн газар, Цагдаагийн газраас гаргуулан авч очиж ажиллах сумдыг сонгов. Мөн тус ажлын санал асуулгыг 85 асуулттайгаар бэлтгэж боловсруулав.

Улмаар Комиссын даргаар ахлуулсан баг Дорнод, Сүхбаатар аймгуудад 5 сарын 8-16-ны өдрүүдэд, 6 дугаар сарын 6-14-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Тариалан, Шинэ-Идэр, Цагаан-Уул сумд, Завхан аймгийн Их-Уул, Цагаанхайрхан, Отгон сумдад, 6 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханхонгор, Баяндалай, Сэврэй сумд, Баянхонгор аймгийн Баянлиг, Богд, Жинст сумдад ажиллаж малчин эмэгтэйчүүдийн төлөөллөөс судалгаа, ярилцлага авч, аймгуудын болон сумдын удирдлагууд, төрийн албан хаагчдаас холбогдох судалгаа, мэдээллийг гаргуулан авч, уулзалт ярилцлага хийж, судалгааны тайланг боловсруулав.



Судалгааны тайланг 12 сарын 13-ны өдөр төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлд нээлттэй танилцуулах уулзалтыг зохион байгуулав.

<b>1.3.6 Санамж бичиг бүхий байгууллагуудтай хамтран судалгаа, дүн шинжилгээний ажил зохион байгуулах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Хөдөлмөрлөх эрх, эвлэлдэн нэгдэх эрхийн тухай хууль тогтоомж, захиргааны шийдвэр, нөхцөл байдлын талаар хамтарсан санал зөвлөмж гаргах ажлын хүрээнд МҮЭХ, УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо, ХЭҮК, МХЕГ, ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сан хамтран 2019 оны 4 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хөдөлмөрлөх эрхийн өнөөгийн төлөв байдал-Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл-Зохистой хөдөлмөр” Үндэсний чуулганаас гаргасан 47 саналын томъёоллыг нэгтгэн судалж, холбогдох саналаа гарган МҮЭХ-тай хамтран ажиллав.



Мөн тус байгууллагатай хамтран 2019 оны 10 дугаар сарын 7-ны өдөр "Зохистой хөдөлмөр-“Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл” дугуй ширээний ярилцлага уулзалтад оролцож, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад албан бус салбарын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн сахилга, эрх хөрөнгийн хариуцлага, хөдөлмөрийн гэрээ, бусад дагалдах гэрээний зохицуулалт, цалин хөлс, олговор, ажил, амралтын цаг, эвлэлдэн нэгдэх хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийн зохицуулалтад гаргасан саналын талаар ярилцаж, холбогдох саналаа Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн ажлын хэсэгт дахин хүргүүлэхээр болов.

10 дугаар сард “Тэгш нийгэм” ТББ-тай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу 21 аймаг дахь Комиссын ажилтнуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн зөрчлийн талаарх кэйс цуглуулах ажлыг хийж, дүнг нэгтгэн тус байгууллагад хүргүүлэв.

1.3.7 Хууль, журамд заасан аргачлалын дагуу ҮАБЗ, ҮСХ, ХЗДХЯ зэрэг байгууллагад холбогдох мэдээлэл, судалгааг хүргүүлэх	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах ажлын хүрээнд Комиссын улирал тутмын танилцуулах мэдээг тогтмол хүргүүлж ажиллав. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх ээлжит тайланд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг 2018-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан болон ҮСХ-д Тогтвортой хөгжлийн зорилго ялгаварлан гадуурхалтын статистик тоог гаргав.

1.3.8 Аймаг, орон нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Комиссын орон нутаг дахь ажилтнууд дараах хуваарийн дагуу аймаг, орон нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлж ажиллав.

Д/д	Аймаг	Агаарын тухай хууль тогтоомжийн талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх	Албан ба насан туршийн боловсрол болон мэргэжлийн үйл ажиллагаан дахь хүний эрхийн сургалтын бодлого, түүний хэрэгжилтийг судалж, дүн шинжилгээ хийх	Малчин эмэгтэйчүүдийн хүчирхийлээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх	Хүний эрхийн хамгаалагчийн эрхийн асуудлаар кэйс, тохиолдол судлах, дүн шинжилгээ хийх	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар кэйс тохиолдолд цуглуулж, дүн шинжилгээ хийх	Өөрсдийн хариуцсан эрх эсвэл өөрсдийн сонгосон нэг сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх
		1 сарын 25	2 сарын 25	4 сарын 15	6 сарын 15	9 сарын 15	11 сарын 15
1	Архангай	I/25	II/25	6-9 сар	VI/17	IX/16	XI/15

-ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН -

2	Баян-Өлгий	XII/11	II/28	6-9 сар		IX/20	XI/21
3	Баянхонгор	I/25	II/25	6-9 сар	XI/14	IX/18	XI/14
4	Булган	I/23		жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй			
5	Говь-Алтай	2019.01.28-ажлаас чөлөөлөгдсөн					
6	Говьсүмбэр	I/25	III/12	6-9 сар		IX/16	XI/16
7	Дархан-Уул	I/25	II/25	6-9 сар	VI/17	IX/13	XI/15
8	Дорнод	II/12		6-9 сар		XI/13	
9	Дорноговь	2019.01.07-жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй, 2019.08.01-ажилд орсон				IX/17	XI/18
10	Дундговь	I/25	II/26	6-9 сар	XI/15	IX/16	XI/15
11	Завхан	I/25	III/2	6-9 сар		IX/18	XI/22
12	Орхон	I/25		6-9 сар			
13	Өвөрхангай	I/28	II/27	6-9 сар		XI/29	XI/29
14	Өмнөговь	XI/15	III/1	6-9 сар	X/23	X/23	XI/15
15	Сүхбаатар	I/25		6-9 сар	XI/15	XI/15	XI/15
16	Сэлэнгэ	I/25	II/25	6-9 сар	XII/01	XI/13	XI/29
17	Төв	I/28	II/25	6-9 сар	VI/16	IX/10	XI/15
18	Увс	I/25	II/24	6-9 сар	VI/14	IX/13	XI/13
19	Ховд	I/25	II/26	жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй		X/01	XI/15
20	Хөвсгөл	I/30	II/26	6-9 сар	XII/08	XI/29	XI/16
21	Хэнтий		II/25	6-9 сар	XI/18	IX/16	XII/08
22	<b>Нийт дүн</b>	<b>18</b>	<b>15</b>	<b>17</b>	<b>11</b>	<b>18</b>	<b>17</b>

Тухайн ажлын чанар, цаг хугацаандаа гүйцэтгэж буй эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүн тус бүрээр гаргаж танилцуулав.


#### 1.4. ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧСӨН ТУХАЙ ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВЧ, ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХ

<b>Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх харьяалах гомдлыг хүлээн авч, ажиллагаа явуулах, бусад хэлтсийн ажилтнуудыг хариуцсан эрхийн чиглэлээр оролцуулах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Комисс 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 622 гомдол хүлээн авч, 582 гомдолд холбогдох ажиллагааг явуулж шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 93.5 хувьтай байна. Ажиллагаанд нийт 44 гомдол ажиллагаанд байна.

Үүнээс орон нутгийн ажилтнууд 205 гомдол хүлээн авч, холбогдох ажиллагаа хийж, 162 гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд 10 гомдол ажиллагаа хийж байна.

**Комисст ирүүлсэн гомдлыг тоог өмнөх онтой харьцуулбал:**



**ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ЭРХИЙН ТӨРЛӨӨР-2019 ОН**

<u>Д/д</u>	<u>Эрхийн төрөл</u>	<u>Нийт</u>	
1	Амьд явах эрх	3	
2	Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх	Орчны бохирдлоос хамгаалуулах эрх	7
		Байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх	1
		Аюулгүй орчинд амьдрах	11
3	Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрх	Эзэмших	6
		Өмчлөх	8
		Ашиглах	
		Өв залгамжлах	
4	Хөдөлмөрлөх эрх	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох	15
		Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах	45
		Цалин хөлс авах	15
		Амрах	
		Хувийн аж ахуй эрхлэх	5
		Албадан хөдөлмөрөөс ангид байх	
		Ажлын байрны дарамт	31
Ажлын байрны бэлгийн дарамт	14		
5	Нийгмийн халамж хүртэх эрх	Эд мөнгөний тусламж авах	42
		Өндөр наслах	
6	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх	23	
7	Сурч боловсрох эрх	19	
8	Оюуны өмчийн эрх		
9	Сонгох, сонгогдох эрх	Сонгох	1
		Сонгогдох	1
10	Эвлэлдэн нэгдэх эрх	1	
11	Жендерийн эрх тэгш байдал	Улс төрийн	
		Эдийн засгийн	
		Соёл боловсрол	
		Эрүүл мэнд	
		Гэр бүлийн харилцаан дахь тэгш байдал	10
		Төрийн албан дахь	
	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь		


-ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН -

12	Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрх		7
13	Халдашгүй чөлөөтэй байх эрх	Эрүү шүүлтээс ангид байх	26
		Хууль бусаар баривчлах	21
		Хууль бусаар цагдан хорих	56
		Гэр бүл, захидал харилцаа	3
		Нэр төрийн халдашгүй байдал	20
		Орон байрны халдашгүй байдал	6
14	Шударга шүүхээр шуулгэх эрх	Хувь хүний нууц	1
14		Хилс хэрэгт холбогдсон	42
		Хууль зүйн туслалцаа авах	81
		Хохирол нөхөн төлүүлэх	6
		Нотлох баримт шалгуулах	7
14	Шүүхэд гомдол гаргах	46	
15	Шашин шүтэх, эс шүтэх эрх		
16	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх	Хэвлэн нийтлэх	
		Жагсаал цуглаан хийх	4
17	Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх		2
18	Чөлөөтэй зорчих эрх		7
19	Иргэний харьяалалтай байх эрх		2
20	Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх	Үндэс, угсаа	1
		Хэл	
		Арьсны өнгө	
		Нас	
		Хүйс	3
		Нийгмийн гарал	2
		Нийгмийн байдал	1
		Хөрөнгө чинээ	
		Эрхэлсэн ажил, албан тушаал	3
		Шашин шүтлэг	1
		Үзэл бодол, боловсрол	2
		Бэлгийн чиг баримжаа	0
		Хөгжлийн бэрхшээл	4
21	Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрх	ХДХВ	
		Зохистой хоол хүнсээр хангагдах эрх	
21	Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрх	Зохистой орон байраар хангагдах эрх	6
		Бусад	
Нийт			622

1.4.2 Хүний эрхийн асуудлаар биечлэн, утсаар болон цахим хэлбэрээр хууль зүйн зөвлөгөө өгөх	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Тайлант хугацаанд нийт 1,030 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль зүйн зөвлөгөө өгсөн байна. Үүнээс утсаар 104, цахимаар 17, биечлэн 677 иргэнд, 19,212 минут буюу 320 цаг 12 минутын хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Үүнээс Улаанбаатар хотод 129 иргэнд 2467 минут буюу 41 цаг 7 минутын хууль зүйн зөвлөгөө, орон нутагт 901 иргэнд 16,212 минут буюу 279 цаг 12 минутын хууль зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

### Хууль зүйн зөвлөгөөг өмнөх онуудтай харьцуулбал



<b>1.4.3 Иргэний зөрчигдсэн эрхийг сэргээлгэх, учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>


Комисс 2019 онд нийт 4 иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

д/д	Нэхэмжлэгч	Нэхэмжлэлийн утга	Үнийн дүн	Хариуцсан гишүүн	Хариуцсан ажилтан
1.	Э	Хууль бусаар эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсаны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх тухай	115.400.0 төг	Ж.Бямбадорж	Л.Дүгэрсүрэн
2.	О	Хууль бусаар эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсаны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх тухай	117.000.0 төг	Ж.Бямбадорж	Б.Мөнх-Эрдэнэ

Комиссоос Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр иргэн Э-г төлөөлөн нэхэмжлэл гаргасан бөгөөд тус шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрээр 35,560,000 төгрөгийн Засгийн газрын нөөц сангаас гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

Мөн Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр иргэн О-г төлөөлөн нэхэмжлэл гаргасан бөгөөд тус шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн шийдвэрээр 9,258,000 төгрөгийг Засгийн нөөц сангаас гаргуулахаар тус тус шийдвэрлэснийг Комиссоос эс зөвшөөрч Нийслэлийн шүүхэд давж заалдах журмаар гомдол гаргахаар ажиллаж байна.

**Төлөөлөн нэхэмжлэлийг өмнөх онуудтай харьцуулбал,**




1.4.4 Шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуульд заасан арга хэмжээ авах, бүртгэл мэдээллийг хөтлөх	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Тайлант хугацаанд Комиссын гишүүний 57 зөвлөмж, 39 шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж ажилласан бөгөөд шаардлага, зөвлөмжийг хариуцан боловсруулсан ажилтнууд хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

**Зөвлөмж:** Комиссын гишүүд 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хооронд нийт - 57 аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд хүргүүлснээс мэдээлийн дагуу 22, гомдлын дагуу 6, хяналт шалгалтын дагуу 23, дүн шинжилгээний дагуу 2, нээлттэй өдрийн хүрээнд 4 нийт 57 Зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 48 зөвлөмжийн хариу ирсэн, 1 зөвлөмж хариу шаардахгүй, 8 зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.


**Зөвлөмжийг өмнөх онуудтай харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.**



**Шаардлага:** Комиссын гишүүдийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хооронд нийт 39 аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд гомдлын дагуу 24, хяналт шалгалтын дагуу 13, мэдээллийн мөрөөр 2 нийт 39 Шаардлага хүргүүлсэн байна. Үүнээс 35 шаардлагын хариу

ирүүлсэн, 2 шаардлагын хариу ирээгүй /албан бичгээр хариу шаардсан/, 2 шаардлагын хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.

**Шаардлагыг өмнөх онуудтай харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.**



**ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт, уулзалт**

**2.1.1 Хүний эрхийн цуврал лекцийг зохион байгуулах**

**Гүйцэтгэлийн хамрах хугацаа**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

2019 онд “Нээлттэй Нийгэм Форум”-тай хамтран 42-47 дахь удаагийн хүний эрхийн цуврал лекцийг ЗГ-ын 11-р байрны дугуй заал, МУИС-д 6 удаа зохион байгуулав.

**ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ**

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ИЛТГЭГЧ НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛАГЫН СУУРИН ТӨЛӨӨЛГӨЧ

**БИАТА ТРАНКМАН**

“ХҮНИЙ ЭРХ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР-2030”

Бүх хүн хаван ч байсан ялгаварлан гадуурхалтаас ангид байж, хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг Дагхийн Зорилгууд хэрхэн баталгаажуулж байгаа талаар илтгэнэ. Мөн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгуудын ахиц дэвшил болон хөгжлийн үйл явц, үр шимээ орхигодож байгаа хүн амд хэрхэн хүрэх, та, би, бид бүгд тогтвортой хөгжлийн төлөө юу хийж чадах вэ гэсэн сэдвүүдээр ярилцана.

ХЭЗЭЭ, ХААНА  
Засгийн Газрын 11-р байрны  
2 дугаар давхарын дугуй танхимд  
2019 оны 5 дугаар сарын 9-ний өдөр 14:00 цагт болно.  
Суудлын тоо хязгаартай тул 262752 утсаар болон  
g.zolzaev@nhrcm.gov.mn цахим шууданаар бүртгүүлнэ үү.  
ЖИЧ: ТӨЛБӨРГҮЙ.

**ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ**

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ТРАНСПЭРСНИС ИНТЕРНЭШЛ МОНГОЛ ТӨВ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**ОЧИРБАТЫН БАТБАЯР**

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭЖ ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН САЙН ЖИШГҮҮД”

Авлига нь хүний эрхийг ноцтойгоор зөрчих үндсэн шалтгаан болдог. Бусад орнуудын хууль тогтоогчид хууль баталж, засгийн газрууд шийдвэр гаргах замаар хэрхэн авлигыг таслан зогсоож, хүний эрхийг хүндэтгэн хангасан талаарх сайн туршлагуудыг хуваалцаж, эдгээр сайн туршлага нь Монгол Улсад хэрэгжих боломжийн тухай илтгэнэ.

ХЭЗЭЭ, ХААНА  
Засгийн Газрын 11-р байрны  
2 дугаар давхарын дугуй танхимд  
2019 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 15:00 цагт болно.  
Суудлын тоо хязгаартай тул 262752 утсаар болон  
g.zolzaev@nhrcm.gov.mn цахим шууданаар бүртгүүлнэ үү.  
ЖИЧ: ТӨЛБӨРГҮЙ.

**ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ**

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН АСУУДААРХ ТУСГАЙ ИЛТГЭГЧ

**МИШЕЛЬ ФОРСТ**

**“ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХАД ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛАГЫН ГҮЙЦЭТЭХ ҮҮРЭГ”**

Хүний эрхийн хамгаалагч нь ганцаар эсхүл бусдадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөт хамгаалах, биелүүлэхийн төлөө тийвэн замаар ажиллаж буй хүмүүс юм. Хэдийгээр тэд тийвэн замаар ажилладаг ч тэдний эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл болон эвлэлдэн нэгдэж үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах, сануулахгүй дугаар мөхөөд эсрэг “орчны” сорил бэрхшээл их байдаг тул Хүний эрхийн Үндэсний Байгууллагаас тэдний хамгаалахад гүйцэтгэх үүргийн талаар ярилцах болно.



**ХЭЗЭЭ, ХААНА**  
Монгол Улсын Их Сургуулийн 1-р байрны 2 дугаар давхрын дугуй танхимд  
2019 оны 9 дугаар сарын 8-ны өдөр 15:00 цагт болно.  
Суудлын тоо хязгаартай тул (51)-262752 утсаар болон [ch.bilguun@nhscm.gov.mn](mailto:ch.bilguun@nhscm.gov.mn) цахим шуудангаар бүртгүүлнэ үү.  
ЖИЧ: ТӨЛБӨРГҮЙ.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС  
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Тусгаар төгсгөлийн тайвны, Засгийн газрын 01 байр, Улаанбаатар Утас: 292752, 262702, Факс: 976-11-326788  
Сайтын хаяг: [www.nhscm.gov.mn](http://www.nhscm.gov.mn)  
Цахим шуудан: [nhscm@nhscm.gov.mn](mailto:nhscm@nhscm.gov.mn)  
Фэйсбүүк хаяг: [www.facebook.com/nhscm](https://www.facebook.com/nhscm)

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мөнхын гэнэв цэцэг 01 Улаанбаатар хот-14240, Монгол Улс  
Утасны дугаар: 976-11-324857  
Факс: 976-11-324857  
Цахим хуудас: [www.forum.mn](http://www.forum.mn)

**ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ**

ЯГОН УЛСЫН ЖАЙКА СУХАБ-ЫН “УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРШЛОЦОГ ДЭМЖИХ” ТӨСВИЙН АХЛАХ ЗӨВЛӨХ

**ЧИБА ХИСАО**

**“ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ”**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэдэнд чиглэсэн ялгаварлан гадуурхалтын талаар, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенц ач холбогдол, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээний талаар ярилцах болно.



**ХЭЗЭЭ, ХААНА**  
Засгийн газрын 11-р байрны 2 дугаар давхрын дугуй танхимд  
2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 15:00 цагт болно.  
Суудлын тоо хязгаартай тул (51)-262752 утсаар болон [ch.bilguun@nhscm.gov.mn](mailto:ch.bilguun@nhscm.gov.mn) цахим шуудангаар бүртгүүлнэ үү.  
ЖИЧ: ТӨЛБӨРГҮЙ.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС  
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Тусгаар төгсгөлийн тайвны, Засгийн газрын 01 байр, Улаанбаатар Утас: 292752, 262702, Факс: 976-11-326788  
Сайтын хаяг: [www.nhscm.gov.mn](http://www.nhscm.gov.mn)  
Цахим шуудан: [nhscm@nhscm.gov.mn](mailto:nhscm@nhscm.gov.mn)  
Фэйсбүүк хаяг: [www.facebook.com/nhscm](https://www.facebook.com/nhscm)

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мөнхын гэнэв цэцэг 01 Улаанбаатар хот-14240, Монгол Улс  
Утасны дугаар: 976-11-324857  
Факс: 976-11-324857  
Цахим хуудас: [www.forum.mn](http://www.forum.mn)

**ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ**

МУБИС-ИЙН НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СҮРГҮҮЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ ТЭНХИЙН АХЛАХ БАГШ, УЛС ТЭРҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР

**ЭРДЭНЭБИЛЭГИЙН ГЭРЭЛТ-ОД**

**“СОНГОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ: СААД БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ”**

Монгол Улсад нам, улс төрчид үйлчилсэн хэвлэл мэдээллийн талцал, үнэт зүйлг суурилуулж намуудан боддог, санал хуваагдан авах, сонгогчдын шилжилт хөдөлгөөн зохион байгуулах эргээр сонгогчийн эрхийн зөрчил түгээмэл байсаар байгаа бөгөөд үнд намуудан төлөвшил, улс төрөөс хараат хэвлэл мэдээлэл, сонгогчийн эрхийг хамгаалахгүй эрх зүйн орчин зарга нь сөргөөр нөлөөлж байна. Иймд сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх замаар тэдний эрхийг хамгаалах талаар та бүхэнтэй санал бодлоо хуваацгааж юм.



**ХЭЗЭЭ, ХААНА**  
МУИС-ийн 1-р байрны 2 дугаар давхрын дугуй танхимд  
2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 15:00 цагт болно.  
Суудлын тоо хязгаартай тул (51)-262752 утсаар болон [ch.bilguun@nhscm.gov.mn](mailto:ch.bilguun@nhscm.gov.mn) цахим шуудангаар бүртгүүлнэ үү.  
ЖИЧ: ТӨЛБӨРГҮЙ.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС  
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Тусгаар төгсгөлийн тайвны, Засгийн газрын 01 байр, Улаанбаатар Утас: 292752, 262702, Факс: 976-11-326788  
Сайтын хаяг: [www.nhscm.gov.mn](http://www.nhscm.gov.mn)  
Цахим шуудан: [nhscm@nhscm.gov.mn](mailto:nhscm@nhscm.gov.mn)  
Фэйсбүүк хаяг: [www.facebook.com/nhscm](https://www.facebook.com/nhscm)

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мөнхын гэнэв цэцэг 01 Улаанбаатар хот-14240, Монгол Улс  
Утасны дугаар: 976-11-324857  
Факс: 976-11-324857  
Цахим хуудас: [www.forum.mn](http://www.forum.mn)

2019 оны 12 дугаар сарын 13-ний өдөр хамгийн сүүлийн олон нийтийн лекцийг Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагчийн газрын Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан “Хүний эрх, хөгжлийн уялдаа” сэдвээр илтгэл тавилаа.

2.1.2 “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалт зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

“Нээлттэй Нийгэм Форум”-тай хамтран “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалт арга хэмжээг 2019 онд дараах хуваарийн дагуу 10 удаа зохион байгууллаа.

Огноо	Сэдэв	Өглөөний зочин
1 дүгээр сарын 24	“Залуучуудын оролцоо, нийгэм дэх байр суурь”	“Лантуун дохио” ТББ-ын тэргүүн, Ид шидийн орон төслийг санаачлагч Ч.Ганжавхлан
2 дугаар сарын 21	“Цахим орчин дахь хүний эрхийн зөрчлүүд, урьдчилан сэргийлэх арга зам”	ЭЦА-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад Д.Эрдэнэбулган
3 дугаар сарын 21	“Агаарын бохирдол ба Эх, хүүхдийн эрүүл мэнд”	“МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээний зохицуулагч, жендэрийн үндэсний шинжээч Д.Энхжаргал
4 дүгээр сарын 18	“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ба Нийгмийн хандлага”	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын дэд дарга Д.Ганболд, хүний эрхийн эксперт, доктор Г.Нарантуяа
5 дугаар сарын 16	“ЛГБТИ хүмүүсийн эрх ба эрүүгийн эрх зүйн орчин”	Нийслэлийн Цагдаагийн газрын УСХ-ийн ахлах мэргэжилтэн, ц/хошууч Э.Баярбаясгалан, ЛГБТ төв



		ТББ-ын эрх зүйн хөтөлбөрийн менежер А.Балдангомбо
6 дугаар сарын 14	“Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл”	Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалт, судалгааны төвийн ахлах прокурор, хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа
9 дүгээр сарын 19	“Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ, тулгамдсан асуудал”	Цагдаагийн Ерөнхий Газрын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газрын эрүүгийн ахлах төлөөлөгч, Цагдаагийн хошууч Б.Мандухай
10 дугаар сарын 24	“Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисоос хамаарал бүхий иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ”	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газар, сэтгэл судлаач, Хар тамхи бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл
11 дүгээр сарын 14	“Хотын хөгжил ба орхигдсон иргэд”	“Дахин төлөвлөлт-Иргэдийн оролцоо” ТББ-уудын нэгдсэн холбооны тэргүүн Б.Нямжав, удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхцэцэг, П.Давааням
12 дугаар сарын 19	“Хог биш баялаг”	“Гялгар уутгүй Монгол” хөдөлгөөнийг санаачлагч М.Бүжинлхам

<b>2.1.3 Эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Энэхүү сургалт зохион байгуулагдаагүй болно.

<b>2.1.4 Магадлан итгэмжлэгдсэн сэдвийн хүрээнд Монголын Хуульчдын Холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүд, шүүгчдэд сургалт зохион байгуулах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Монголын хуульчдын холбооны Хуульчдын үргэлжилсэн сургалтын хорооноос магадлан итгэмжилсэн сэдвүүдийн хүрээнд дараах сургалтуудад Комиссын гишүүд, ажилтнууд сургагч багшаар оролцов.

Огноо	Сэдэв	Цаг	Хаана
3 дугаар сарын 27	“Хүний эрхийн олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх нь”	4	Монголын хуульчдын холбоо
4 дүгээр сарын 18	“Хүүхдийн эрх хамгаалал”	4	МӨХ
5 дугаар сарын 8	“Жендэр ба хүний эрх”	4	Монголын хуульчдын холбоо
9 дүгээр сарын 8	“Хүүхдийн эрх хамгаалал”	4	МӨХ
9 дүгээр сарын 8	“Эрүү шүүлтээс ангид байх эрх”	4	МӨХ
10 дугаар сарын 21	“Хүний эрхийн олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх нь”	4	Монголын хуульчдын холбоо

12 дугаар сарын 7	“Хүүхдийн эрх хамгаалал”	4	МӨХ
12 дугаар сарын 8	“Хүний эрхийн олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх нь”	4	МӨХ
12 дугаар сарын 21	“Хүний эрхийн олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх нь”	4	МӨХ
12 дугаар сарын 22	“Хүүхдийн эрх хамгаалал”	4	МӨХ

<b>2.1.5 Хүний эрх, жендэрийн сургалтын агуулгыг тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтын ангиллаар боловсруулах ажлыг эхлүүлэх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Сургалтын гарын авлага боловсруулах ажлын хүрээнд Комиссын гишүүн П.Оюунчимэг НҮБХХ-ийн төслийн зохицуулагч П.Хулангоо, Удирдлагын академийн багш нартай уулзалт хийв. Улмаар 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Монголын хуулийн корпораци” ХХН-тэй сургалтын агуулгыг боловсруулах Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулав.

Сургалтын агуулгыг төрийн албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлүүд үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллах, хүний эрхийн мэдрэмжтэйгээр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх мэдлэг, хандлагыг бэхжүүлэхэд зориулан боловсруулж, ийнхүү гүйцэтгэхдээ дараах бүтэц, агуулгыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн тусгахаар гэрээлэв:

1. Жендэр ба хүний эрхийн харилцан хамаарал, ойлголт, үзэл баримтлал
2. Жендэр ба хүний эрхэд суурилсан хөгжлийн харилцан хамаарал
3. Жендэрээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүд, ялгаварлан гадуурхалтын асуудал
4. Жендэрийн тэгш байдлын талаарх үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт
5. Төрийн албан дахь жендэрийн тэгш байдал
6. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, gender mainstreaming
7. Төрийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа, төлөвлөлтөд төрийн албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэдийн гүйцэтгэх үүрэг

<b>2.1.6 Жендэр, ажлын байрны дарамт болон бэлгийн дарамтын асуудлаар заавал хамрагдах сургалтын модуль боловсруулах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

НҮБХХ-тэй тохиролцож, энэ ажлын гүйцэтгэлийг хойшлуулав.

<b>2.1.7 Сургагч багш нарын сүлжээнд дэмжлэг үзүүлэх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

НҮБХХ-тэй тохиролцож, энэ ажлын гүйцэтгэлийг хойшлуулав.

<b>2.1.8 ХЭҮК-ын ажилтнууд болон хяналт тавих чиг үүрэг бүхий бусад байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

**сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах**

**Нэг. “Жендэр ба хүний эрх” сэдэвт семинар**

2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Бишрэлт зочид буудлын хурлын танхимд нийгмийн ухааны чиглэлээр хичээл ордог их, дээд сургуулийн багш нарын дунд “Жендэр ба хүний эрх” сэдэвт семинарыг зохион байгуулав. Уг семинарыг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан оюутан, залуучуудад олгож буй хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүний эрхийн хичээл зааж буй багш нарын хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, чадавхийг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөрөөр олгож буй хүний эрх, жендэрийн талаарх үзэл баримтлал, ойлголтыг нэгтгэх зорилгоор зохион байгуулж дараах хөтөлбөрийн дагуу оролцогчидтой харилцан мэдээлэл солилцов.

Нээлт	ХЭҮК-ын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл
“Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо”	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрхийн олон улсын гэрээ</li> <li>- НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороод, тэдгээрт гомдол гаргах</li> </ul>
Цай, кофе	
Хүний эрхийн олон улсын индекс: Монгол улсын эрэмбэ, түвшин	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрхийн асуудлуудаар олон улсад гаргаж буй индексүүд</li> <li>- Шалгуур үзүүлэлт</li> <li>- Монгол улсын эрэмбэ, түвшин</li> </ul>
“Хүний эрхийн боловсрол”	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрхийн боловсролын үндсэн ойлголт, зарчим</li> <li>- Хүний эрхийн боловсрол практикт</li> </ul>
Үдийн хоол	
“Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал” “Жендэрийн тэгш байдлын талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт”	<ul style="list-style-type: none"> <li>- Тэгш байдлын талаарх үзэл баримтлалууд</li> <li>- Жендэрийн тэгш байдлын зарчим</li> <li>- Жендэрийн олон улсын индекс</li> <li>- Хүний эрхийн билл</li> <li>- НҮБ-ын конвенц</li> </ul>
Цай, кофе	
“Жендэрийн ялгаварлан гадуурхалт” “Жендэрт суурилсан хүчирхийлэл”	<ul style="list-style-type: none"> <li>- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх</li> <li>- Жендэрийн хүчирхийллийн хэлбэрүүд</li> <li>- ХЭҮК-т жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдол шийдвэрлэх</li> </ul>
Семинарын дүгнэлт, хаалт	

Семинарт Улаанбаатар их сургууль, МУБИС, АШУҮИС, ШУТИС, ХААИС, ОУ-ын Улаанбаатар ИС, Дотоод хэргийн их сургуулийн Хилийн сургууль, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, Батлан хамгаалахын их сургуулийн нийт 18 багш ирж оролцов.

**Хоёр. “Их, дээд сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол: Жендэрийн эрх тэгш байдал” сэдэвт дугуй ширээний уулзалт**

2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Засгийн газрын 11-р байрны 2 давхрын хурлын дугуй танхимд их, дээд сургуулийн удирдлагуудын дунд “Их, дээд сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол: Жендэрийн эрх тэгш байдал” сэдэвт дугуй ширээний уулзалтыг зохион байгуулав. Уг уулзалтаар их, дээд сургуулиудад сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургуулиуд дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийн асуудлаар туршлага солилцож, сургалтын агуулга, нэр томъёо, ойлголтын зөрүүг нэгтгэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой байсан ба дараах хөтөлбөрийн дагуу зохион байгуулав.

Уулзалтад ХЭҮК-ын удирдлагууд, их, дээд сургуулиудын захирал, сургалт, хөтөлбөр хариуцсан албаны дарга, менежер, багш нар хүрэлцэн ирэв.

<b>ХӨТӨЛБӨР</b>		
<b>14:00-14:20</b>	<b>Нээлтийн үг</b>	ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг
<b>14:20-14:40</b>	“Дээд боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол” танилцуулга	Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл
<b>14:40-15:00</b>	“Хүний эрхийн боловсрол: Жендэрийн эрх тэгш байдлын талаарх үзэл баримтлалыг дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдал” танилцуулга	БСШУСЯ
<b>15:00-16:40</b>	<p><b>Хэлэлцүүлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрх хичээл сургалтын хөтөлбөрт туссан байдал, агуулга</li> <li>- Хүний эрхийн боловсролын чиглэлээр их, дээд сургуулиудад хэрэгжүүлж буй сайн туршлага, тулгамдаж буй бэрхшээл</li> <li>- ХЭҮК болон их, дээд сургуулийн хамтын ажиллагааны хүрээ</li> </ul>	Чиглүүлэгч ХЭБСХ-ийн дарга Г.Агар-Эрдэнэ
<b>16:40-17:00</b>	<b>Дүгнэлт, хаалт</b>	ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг

### **Гурав. Төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Жендэр ба хүний эрх” сургалт**

Комисс нь Төрийн албаны зөвлөлөөс 2018-2021 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд төрийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг бий болгоход төрийн албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулах, төрийн байгууллагын удирдах ажилтнуудын жендэр ба хүний эрхийн мэдлэг, чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2019 оны 4-12 дугаар сард сард Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Архангай, Төв, Хөвсгөл, Булган гэсэн нийт 16 аймагт “Жендэр ба хүний эрх” сургалтыг зохион байгуулав. Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд ЗГХЭГ руу албан бичиг хүргүүлж, ЗГХЭГ-аас 16 аймгийн ЗДТГ-т сургалтад зохион байгуулалт сайтай оролцох талаар албан бичгүүдийг хүргүүлсэн байна.

Сургалтыг Ажлын албаны даргын баталсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан ба сургалтын үеэр санал солилцох, асуулт хариулт, харилцан ярилцаж идэвхтэй, чөлөөтэй оролцсон бөгөөд, сургалттай холбоотой ямар нэг хүндрэл,

бэрхшээл гараагүй болно. Сургалтад ХЭҮК-ын гишүүн, ажлын албаны ажилтнууд сургагч багшаар оролцов. Сургалтын оролцогчдод “Жендэр ба хүний эрх” сургагч багшийн гарын авлага, “Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин” гарын авлага, “Жендэр ба хүний эрх” төрийн байгууллагын албан хаагчдад зориулсан ном, постер, эвхэмэл хуудас, “Хүний эрхийн олон улсын билл” ном, Комиссын дэвтэр, бал тус тус түгээсэн бөгөөд цайны завсарлагыг зохион байгуулав. Сургалтад оролцогчдын үдийн хоолны зардлыг тухайн аймгийн ЗДТГ-аас хариуцсан болно.

Аймаг тус бүрт 30 удирдах ажилтанд сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн ч Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 26, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 18, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 53, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 11, Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 34, Дундговь аймгийн хүсэлтээр 30, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 16, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 16, Завхан аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 7, Архангай аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 8, Төв аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 8, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 9, Булган аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр 2 ажилтныг нэмж оролцуулсан болно.

Сургалтын оролцогчдод “Жендэр ба хүний эрх”, сургагч багшийн гарын авлага, “Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин”, “Жендэр ба хүний эрх” төрийн байгууллагын албан хаагчдад зориулсан ном, постер, эвхэмэл хуудас, Олон улсын билл, Комиссын дэвтэр, бал түгээж ажиллав. Сургалтын үнэлгээний хуудсыг нэгтгэн, илтгэх хуудас, санхүүгийн тайланг боловсруулав.

#### ***2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр. Өвөрхангай аймаг***

Аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд зохион байгуулсан сургалтад ЗДТГ, Арвайхээр сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, Тагнуулын хэлтэс, МСҮТ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША, Ерөнхий боловсролын сургууль зэрэг төрийн байгууллагын 56 удирдах ажилтан (25 эрэгтэй, 31 эмэгтэй) хамрагдав.

#### ***2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр. Баянхонгор аймаг***

Аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, НДХ, ХХААГ, ШШГГ, Татварын хэлтэс, Политехникийн коллеж, БТСГ, ОНӨГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Цэцэрлэг, сумдын ЗДТГ, Автотээвэр төв зэрэг төрийн байгууллагын 48 ажилтан (24 эрэгтэй, 24 эмэгтэй) хамрагдав.

#### ***2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Говь-Алтай аймаг***

Аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Есөнбулаг сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, Татварын хэлтэс, МСҮТ, ХХААГ БТСГ, ОНӨГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний газар, Насан туршийн боловсролын төв, Орон нутаг судлах музей, Сум дундын ойн анги, Нийтийн номын сан зэрэг төрийн байгууллагын 29 ажилтан (20 эрэгтэй, 9 эмэгтэй) хамрагдав.

#### ***2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр. Сэлэнгэ аймаг***

Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, 17 сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, ШША, ОБГ, Татварын хэлтэс, Гаалийн газар, ХХААГ БТСГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны

шинжилгээнийгазар зэрэг төрийн байгууллагын 83 ажилтан (30 эрэгтэй, 53 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр. Орхон аймаг**

Орхон аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, ШША, ОБГ, Татварын хэлтэс, Гаалийн газар, ХХААГ БТСГ, ОНӨГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний газар зэрэг төрийн байгууллагын 30 ажилтан (21 эрэгтэй, 9 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр. Дархан-Уул аймаг**

Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, ШША, ОБГ, Татварын хэлтэс, ХХААГ БТСГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Нэгдсэн эмнэлэг зэрэг төрийн байгууллагын 41 ажилтан (26 эрэгтэй, 15 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр. Өмнөговь аймаг**

Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, 15 сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, ШША, ОБГ, Татварын хэлтэс, Гаалийн газар, ХХААГ БТСГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээнийгазар зэрэг төрийн байгууллагын 64 ажилтан (31 эрэгтэй, 33 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 6 дугаар сарын 20-ны өдөр. Дундговь аймаг**

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ШШГГ, ШША, ОБГ, Татварын хэлтэс, Гаалийн газар, ХХААГ БТСГ, ЦГ, УБХ, ЭМГ Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, БСУГ, Статистикийн хэлтэс, Ус цагуур, орчны шинжилгээний газар зэрэг төрийн байгууллагын 60 ажилтан (29 эрэгтэй, 31 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр. Хэнтий аймаг**

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, ИТХ, Хэрлэн сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Орон нутгийн өмчийн газар, ШШГГ, ЭМГ, БТСГ, Номын сан, ХХААГ, ШУГ, БОАЖГ, ГБХЗХГ, ХХҮГ, Нэгдсэн эмнэлэг, ОБГ зэрэг төрийн байгууллагын 30 ажилтан (16 эрэгтэй, 14 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр. Сүхбаатар аймаг**

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газарын Хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, ИТХ, Зарим сумдын ЗДТГ, Цагдаагийн газар, ЕБС, ЭМГ, БСУГ, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, ГБХЗХГ, УБХ, Зэвсэгт хүчний анги, Статистикийн хэлтэс, Шуудан холбоо, ХХҮГ, МЭГ, СХАА, УЦУОШТ, ХМОНХА, МСҮТ, СХЗХ, ХЖТ, АНЭ, БТСГ, НДХ, Номын сан, ХХААГ, БОАЖГ, Төрийн аудит зэрэг төрийн байгууллагын 46 ажилтан (22 эрэгтэй, 24 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр. Дорнод аймаг**

Дорнод аймгийн Татварын хэлтсийн сургалтын танхимд зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, ИТХ, Дорнод Их сургууль, УБХ, ЭМГ, УЦУОШТ, Статистикийн хэлтэс, ШШАлба, ХДТеатр, ШШГА, ГБХЗХГ, ХХҮГ, БСУГ, Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, Номын сан, Аймгийн Музей, МХГ, БОАЖГ, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар, ХХААГ, БТСГ зэрэг төрийн байгууллагын 30 ажилтан (16 эрэгтэй, 14 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр. Завхан аймаг**

Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Улиастай сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША, Ерөнхий боловсролын сургууль зэрэг төрийн байгууллагын 37 ажилтан (15 эрэгтэй, 22 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр. Архангай аймаг**

Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Цэцэрлэг сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША, Ерөнхий боловсролын сургууль зэрэг төрийн байгууллагын 38 ажилтан( 11 эрэгтэй, 27 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр. Төв аймаг**

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Зуун мод сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША, Ерөнхий боловсролын сургууль зэрэг төрийн байгууллагын 38 ажилтан (17 эрэгтэй, 21 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 12 дугаар сарын 2-ны өдөр. Хөвсгөл аймаг**

Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Мөрөн сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША, Ерөнхий боловсролын сургууль зэрэг төрийн байгууллагын 39 ажилтан ( 27 эрэгтэй, 12 эмэгтэй) хамрагдав.

**2019 оны 12 дугаар сарын 6-ны өдөр. Булган аймаг**

Булган аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн ЗДТГ, Булган сумын ЗДТГ, ИТХ, НДХ, ХХААГ, ШШГГ, ЦГ, МХГ, УБХ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ГБХЗХГ, БОАЖГ, ХХҮГ, Статистикийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, ЭМГ, ОБГ, Прокурорын газар, Шүүх, ШША зэрэг төрийн байгууллагын 32 ажилтан (27 эрэгтэй, 5 эмэгтэй) хамрагдав.

2.1.9 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны төвтэй харилцаж, e-khutuch.mn вэб сайтад Комиссын жил бүрийн илтгэл, судалгааны тайлан, хэвлүүлсэн ном товхимлыг байршуулахаар тохиролцсоны дагуу дараах мэдээллийг бэлтгэн хүргүүлээд байна. Үүнд

- Комиссын танилцуулга
- Комиссын үйл ажиллагаанд хамаарал бүхий эрх зүйн акт, түүний заалт
- ХЭҮК-т гомдол хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа
- ХЭҮК-с төлөөлөн нэхэмжлэл гаргах үйл ажиллагаа
- ХЭҮК-ын орон нутгийн ажилтнуудын мэдээлэл
- ХЭҮК-ийн гишүүний шаардлага, зөвлөмж
- ХЭҮК-оос гаргасан судалгаа, илтгэл, ном товхимолын жагсаалт, татаж авах холбоос, линк

Уг хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан “Эрх зүйн хөтөч ажиллуулах журам”-ын төслийг 2019 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэхэд оролцож журмыг батлуулав.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Комиссоос авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг боловсруулж 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр 4/133 тоот албан бичиг, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд болон Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгийн E-khutuch хөтөлбөрийн менежер У.Түвшинтулгад цахим шуудангаар хүргүүлэв.

2.1.10 Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-тай хамтран сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Энэ ажлыг 2019 онд үргэлжлүүлэн зохион байгуулахаар тус дүүргээс санал болгож жилийн төлөвлөгөөнд оруулсан боловч уг ажил хийгдээгүй болно.

2.1.11 Орон байраар хангагдах эрхийн асуудлаарх үндэсний зөвлөгөөнийг хамтран зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Монголын Эмнести Интернэшнл, Монголын Хуульчдын Холбоо болон Отгонтэнгэр Хууль зүйн сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран хамтран 2015, 2017 онд хот төлөвлөлт, газар чөлөөлөлт, хүний эрхийн асуудлаар онол, практикийн бага хурлыг зохион байгуулсан бөгөөд хоёр жил тутмын энэхүү онол практикийн бага хурлыг 2019 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндэсний зөвлөлдөх уулзалт болгон өргөжүүлэн зохион байгуулж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 17 дахь илтгэлд дэвшүүлсэн санал зөвлөмжийн хүрээнд хэлэлцэж болсонтой холбогдуулан Комиссоос хийх бэлтгэлийг хангаж ажиллав.

“Хот дахин төлөвлөлт-газар чөлөөлөлт, хүний эрх” Үндэсний зөвлөлдөх уулзалтын хөтөлбөрийн төсөл, төрийн байгууллагын оролцогчдыг тодорхойлох, зохион байгуулах газрыг олж, гэрээг хийх, түүнчлэн Комиссын даргын хэлэх үг, Ерөнхий сайдын илгээлт зэргийг боловсрууллаа. Нийт 6 газар албан бичгийн төслийг боловсруулж, Комиссын дарга, Ажлын албаны даргад танилцуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Үндэсний зөвлөлдөх уулзалтад 150 оролцож, амжилттай зохион байгуулав. Үндэсний зөвлөлдөх уулзалтаар талуудын илэрхийлсэн байр суурь болон гаргасан санал зөвлөмжийн төслийг судалж,



холбогдох байгууллагуудад хүргүүлэх эхний саналын төслийг боловсруулж, Монголын Эмнести Интернэшнлд хүргүүлэв.

2.1.12 Санамж бичгийн хүрээнд болон байгууллагын хүсэлт, захиалгаар хүний эрхийн сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

2019 онд Комисс 744.9 цагийн сургалтыг, 21,986 хүнд зохион байгуулсан байна. Үүнээс Комиссын төвийн ажилтнууд нийт 96 удаа, 322 цагийн сургалт хийж, 6,890 хүн хамруулсан бол орон нутаг дахь ажилтнууд нийт 422.9 цагийн сургалтыг 15,096 хүнд зохион байгуулж хамруулсан байна. Сургалтыг сар сарын дэлгэрэнгүй мэдээллийг дор оруулав.

**1 дүгээр сард** Улаанбаатар хотод 5 удаагийн 8.5 цагийн сургалт хийж 160 хүн хамрагдсанаас 109 эрэгтэй, 51 эмэгтэй байсан бол орон нутагт Архангай, Баян-Өлгий, Булган, Дундговь аймгуудад нийт 7 удаагийн 13.5 цагийн сургалтыг зохион байгуулж, 201 хүн хамруулсны 93 нь эрэгтэй, 108 нь эмэгтэй байна.

Нийт 12 удаагийн 22 цагийн сургалтыг зохион байгуулж, 361 хүнийг хамруулснаас 202 эрэгтэй, 159 эмэгтэй байна.

**2 дугаар сард** Улаанбаатар хотод Ахмад настны эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ, зарчим, ХДХВ, ДОХ ба хүний эрх сэдвүүдээр 2 удаагийн 2 цагийн сургалт хийж аймаг, нийслэл, дүүрэг, яам агентлаг, зарим аж ахуйн нэгжийн ахмадын байгууллагын удирдах ажилтнууд, ХХЕГ-ын харьяа анги, байгууллагуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтнууд зэрэг 75 хүн хамруулснаас 51 эрэгтэй, 24 эмэгтэй байсан бол орон нутагт Архангай, Дархан-Уул, Дундговь, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгуудад нийт 9 удаагийн 240 цагийн сургалтыг зохион байгуулж 201 хүн хамруулсаны 142 нь эрэгтэй, 98 нь эмэгтэй байна.

Нийт 11 удаагийн 242 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 6 аймагт зохион байгуулж 276 хүнийг хамруулсны 193 нь эрэгтэй, 122 нь эмэгтэй байна. Мөн цагдаагийн албан хаагчдад зориулсан давтан сургалтыг 2 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд ЦЕГ-ын сургалтын төв дээр зохион байгуулж өмнө нь сургагч багшаар бэлтгэгдсэн 35 алба хаагчийг хамруулав.

**3 дугаар сард** Улаанбаатар хотод Ахмад настны эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ, зарчим, ХДХВ, ДОХ ба хүний эрх, Хөдөлмөрлөх эрх, Хүүхдийн эрх, Гэр бүлийн хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эрх, Үндсэн хууль ба хүний эрх зэрэг сэдвүүдээр 9 удаагийн 29 цагийн сургалт хийж цагдаагийн байгууллагын удирдах ажилтнууд болон хүний эрхийн сургагч багш нар, үйлдвэрчний эвлэлийн гишүүн, идэвхтэн, сонгуультаан, хөдөлмөрийн хяналтын байцаагчид, ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтнууд, аймгуудын ЗД-ын орлогч дарга нар, шүүгчид, ЗХЖШ-ын ахлагч нар, ОУ-ын Найрамдал цогцолборын ажилтнууд зэрэг 546 хүн хамруулснаас 246 эрэгтэй, 212 эмэгтэй байсан бол орон нутагт 11 аймаг, Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгуудад нийт 28 удаагийн 37 цагийн сургалтыг зохион байгуулж 1579 хүн хамруулсны 142 нь эрэгтэй, 98 нь эмэгтэй байна.

Нийт 37 удаагийн 66 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 11 аймагт зохион байгуулж 2155 хүнийг хамруулсны 623 эрэгтэй, 967 эмэгтэй байна.

**4 дүгээр сард** Улаанбаатар хотод “Жендэр ба хүний эрх”, “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний эрхэд суурилсан хорих байгууллага”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Хүний эрхийн олон улсын гэрээ”,

“Ажлын байрны дарамт” зэрэг сэдвүүдээр 10 удаагийн 16 цагийн сургалт хийж цагдаагийн байгууллагын алба хаагчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, ЗХЖШ-ын харьяа 150 дугаар ангийн алба хаагчид, ШШГЕГ-ын харьяа ангиудын удирдлагууд, алба хаагчид зэрэг 462 хүн хамруулснаас 364 эрэгтэй, 98 эмэгтэй байсан бол орон нутагт 14 аймаг, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Увс, Орхон, Өвөрхангай, Хэнтий аймгуудад нийт 26 удаагийн 38 цагийн сургалтыг зохион байгуулж 1278 хүн хамруулсаны 417 нь эрэгтэй, 861 нь эмэгтэй байна.

Нийт 36 удаагийн 54 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 14 аймагт зохион байгуулж 1740 хүнийг хамруулсны 781 эрэгтэй, 959 эмэгтэй байна.

**5 дугаар сард** Улаанбаатар хотод Жендэр ба хүний эрх, Эрүү шүүлтээс ангид байх эрх, Хүний эрхийн олон улсын гэрээ зэрэг сэдвүүдээр 16 удаагийн 37.5 цагийн сургалт хийж цагдаагийн байгууллагын алба хаагчид, ШШГЕГ-ын харьяа ангиудын алба хаагчид зэрэг 1148 хүн хамруулснаас 597 эрэгтэй, 551 эмэгтэй байсан бол орон нутагт 11 аймаг, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Төв, Увс, Өмнөговь, Хэнтий аймгуудад нийт 42 удаагийн 76 цагийн сургалтыг зохион байгуулж 1951 хүн хамруулсаны 703 нь эрэгтэй, 1248 нь эмэгтэй байна.

Нийт 58 удаагийн 113.5 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 11 аймагт зохион байгуулж 3099 хүнийг хамруулсны 1300 эрэгтэй, 1799 эмэгтэй байна.

**6 дугаар сард** Улаанбаатар хотод Жендэр ба хүний эрх сэдвээр ЗХЖШ-ын харьяа анги байгууллагуудад, ИБУТЭТОУП- багц сургалтыг прокуроруудад, Хөгжлийн бэрхшээл ба жендэрийн тэгш байдал сэдэвт сургалтыг Тэгш нийгэм холбоо ТББ-тай хамтран орон нутаг, Улаанбаатар хотын ХБИргэдэд, Хүний эрхийн үндсэн ойлголт, Эрүү шүүлтээс ангид байх эрх сэдвээр цагдаагийн алба хаагчдад, нийт 8 удаагийн 27 цагийн сургалт хийлээ. Сургалтад 453 хүн хамруулснаас 273 эрэгтэй, 104 эмэгтэй байна. Орон нутагт 7 аймагт (Баянхонгор, Баян-Өлгий, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Хэнтий) нийт 21 удаагийн 47,5 цагийн сургалтыг зохион байгуулж 755 хүн хамруулсаны 227 нь эрэгтэй, 528 нь эмэгтэй байна.

Нийт 29 удаагийн 74.5 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 7 аймагт зохион байгуулж 1208 хүнийг хамруулсны 500 эрэгтэй, 632 эмэгтэй байна.

**7, 8 дугаар сард** Улаанбаатар хотод “Жендэр ба хүний эрх” сэдвээр ЗХЖШ-ын харьяа анги байгууллагуудад, Эрүү шүүлтээс ангид байх эрх сэдвээр ШШГЕГ-ын харьяа ангиудад нийт 6 удаагийн 20 цагийн сургалт хийлээ. Сургалтад 627 хүн хамруулснаас 520 эрэгтэй, 107 эмэгтэй байна. Орон нутагт 5 аймагт (Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Увс, Орхон) нийт 26 удаагийн 21,4 цагийн сургалтыг зохион байгуулж 1714 хүн хамруулсаны 1240 нь эрэгтэй, 474 нь эмэгтэй байна.

Нийт 32 удаагийн 41.4 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 5 аймагт зохион байгуулж 2341 хүнийг хамруулсны 1760 эрэгтэй, 581 эмэгтэй байна.

**9 дүгээр сард** нийт 28 удаагийн 32 цаг 40 минутын сургалтыг Улаанбаатар хот болон 10 аймагт зохион байгуулж 1015 хүнийг хамруулсны 555 эрэгтэй, 472 эмэгтэй байна.

**10 дугаар сард** Улаанбаатар хотод Жендэр ба хүний эрх сэдвээр Цагдаагийн байгууллага, ИНЕГ, Хүүхдийн эрхийн асуудлаар МХЕГ, Ахмад настны эрхийн асуудлаар СХД, ЧД-ийн ахмадууд, Эрүү шүүлтээс ангид байх эрх сэдвээр ШШГЕГ-ын харьяа ангиудын алба хаагчидад мөн Хүний эрх нээлттэй өдөр арга хэмжээний

хүрээнд 4 аймагт, нийт 11 удаагийн 41 цагийн сургалт хийлээ. Сургалтад 556 хүн хамруулснаас 150 эрэгтэй, 314 эмэгтэй байна. Орон нутагт 9 аймагт (Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Хэнтий) нийт 31 удаагийн 37 цагийн сургалтыг зохион байгуулж 1126 хүн хамруулсаны 375 нь эрэгтэй, 751 нь эмэгтэй байна.

Нийт 42 удаагийн 78 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 9 аймагт зохион байгуулж 1682 хүнийг хамруулсны 525 эрэгтэй, 1065 эмэгтэй байна.

**11 дүгээр сард** Улаанбаатар хотод Жендэр ба хүний эрх, АББД сэдвээр Цагдаагийн байгуулага, ИНЕГ, Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн алба хаагчид, их дээд сургуулийн оюутнууд, Хөдөлмөрлөх эрхийн асуудлаар цагдаагийн алба хаагчидад нийт 11 удаагийн 17 цагийн сургалт хийлээ. Сургалтад 1506 хүн хамруулснаас 688 эрэгтэй, 442 эмэгтэй байна. Орон нутагт 9 аймагт (Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Төв, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий) нийт 29 удаагийн 46,5 цагийн сургалтыг зохион байгуулж 2174 хүн хамруулсаны 425 нь эрэгтэй, 1591 нь эмэгтэй байна.

Нийт 40 удаагийн 63,5 цагийн сургалтыг Улаанбаатар хот болон 9 аймагт зохион байгуулж 3680 хүнийг хамруулсны 1113 эрэгтэй, 2033 эмэгтэй байна.

**12 дугаар сард** Улаанбаатар хот, 11 аймагт (Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Төв, Өмнөговь, Хэнтий) нийт 47 удаа 58 цагийн сургалт хийж 1814 хүн хамрагдсан байна.

Үүнээс Улаанбаатар хотод 6 удаа, 18 цагийн сургалт хийж 389 хүн хамруулсан бол орон нутагт 41 удаа, 40 цагийн сургалт хийж 1425 хүн хамруулсан байна.

## 2.2 Хүний эрхийн сурталчилгаа

2.2.1 “Хүний эрхийн мэдээллийн хуудас”-ыг бэлтгэн хэвлүүлэх, цахим хуудаст байршуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

“Хүний эрхийн мэдээллийн хуудас”-ын 2019 оны 1 дүгээр улирлын дугаарыг 500 хувь хэвлүүлсэн ба 2, 3, 4 дүгээр улирлын дугаар хэвлэгдээгүй болно.

2.2.2 “Хүний эрх” сэтгүүлийг бэлтгэн хэвлүүлэх, цахим хуудаст байршуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Комиссоос 17 дахь жилдээ эрхлэн гаргаж буй "Хүний эрх" сэтгүүл International Standard Serial Number (ISSN) буюу Олон улсын стандарт дугаартай болсон ба дэлхий нийтэд түгээгдэж буй 2 сая гаруй хэвлэмэл болон дижитал бүтээгдэхүүний сан хөмрөгт "Хүний эрх" сэтгүүл багтаж, хадгалагдах боломж нээгдэв. “Хүний эрх” сэтгүүл нь ISSN: 2617-9288 (цахим), ISSN: 2617-927X (хэвлэл) дугаартай болсон бөгөөд дэлхийн аль ч улсын номын сангаас тус сэтгүүлийн талаарх мэдээллийг авах боломжтой болсон байна.

“Хүний эрх” сэтгүүлийн 2019/1 дугаарыг “Хөх судар принт” ХХК-д 500 хувь, 2019/02 дугаарыг “Хөх судар принт” ХХК-д 500 хувь хэвлүүлэв.

2.2.3 “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид”	Гүйцэтгэлийн хамрах хугацаа

клубыг чадавхижуулах сургалт, уулзалт зохион байгуулах	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12


Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх "Хүний эрхийн төлөө сэтгүүлчид" клубын уулзалтыг дараах хуваарийн дагуу зохион байгуулав.

1 дүгээр сарын 11	"Клубын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх", "ХЭҮК-ын 2019 оны төлөвлөгөө", "Иргэдийн гомдлыг шийдвэрлэж буй байдал"
3 дугаар сарын 14	"Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн асуудлууд, эрх зүйн зохицуулалт", "Жендэрийн чиглэлээр ХЭҮК-оос явуулж буй үйл ажиллагаа, дэлхий нийтийн чиг хандлага"
4 дүгээр сарын 26	"Хүний эрхийн үндэсний комисст ирүүлсэн гомдлыг шийдвэрлэж буй нөхцөл байдал"
6 дугаар сарын 28	Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалт, судалгааны төвөөс гаргасан 2 боть судалгаа болон ХЭҮК-оос хийж буй ажлууд, тухайлбал малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж байгаа талаарх мэдээлэл
8 дугаар сарын 27	Монгол Улсад зохион байгуулж буй "Тэгш эрх, бахархлын аян өдрүүд" цогц арга хэмжээ, "НҮБ-ын хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх тусгай илтгэгч Мишель Форст манай улсад дахин ажиллах болсон тухай болон сүүлийн үед ХЭҮК-оос зохион байгуулж буй үйл ажиллагааны тойм мэдээлэл"
9 дүгээр сарын 30	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын дүн"
10 дугаар сарын 6	"ХЭҮК-т иргэдээс ирүүлсэн гомдол шийдвэрлэлт", "ОУ-ын индекс ба Монгол Улсын эрэмбэ"
12 дугаар сарын 10	Хүний эрхийн олон улсын өдрийн хүрээнд Монголын Эмнести интернэшнл байгууллагатай хамтран "Хүний эрхийн хамгаалагч баатар" хөрөг найруулал бичих уралдааны болзлыг танилцуулах, Хүний эрхийн өдрийн хүрээнд хамтран ажиллах талаарх мэдээлэл

2.2.4 Хүний эрхийн чиглэлээр ном, товхимол хэвлүүлэх	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Комиссоос 2019 онд дараах ном, товхимлыг хэвлүүлэв.

- Хүүхдийн эрхийн асуудлаарх "Шинэ өдөр" комик ном. 1,000 хувь хэвлүүлсэн.
- "Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар ХЭҮБ-аас хяналт шалгалт, мониторинг хийх удирдамж" гарын авлагыг ажлын хэрэгцээнд хэрэглэхээр орчуулсан.
- "Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "Жендэрийн эрх тэгш байдал" сэдэвт 4 багц ил захидал. 10,000 хувь хэвлүүлсэн.
- "Хүний эрхийн олон улсын билл" ном. 6, 7 дахь хэвлэлт.
- НҮБ-ын Хүн амын сангаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" ном. 460 хувь хэвлүүлсэн.



2.2.5 Олон улсын хүний эрхийн өдрийн арга хэмжээг зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Олон улсын хүний эрхийн өдрийн арга хэмжээг Ажлын албаны даргын баталсан төлөвлөгөөний дагуу удирдамж батлуулж, удирдамжид заасан төлөвлөгөөт ажлуудыг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. “Эрхийнхээ төлөө нэгдэцгээ” аянг хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагуудын Хүний эрхийн форумтай анх удаа хамтран Улаанбаатар хот болон 21 аймагт зохион байгууллаа. ХЭҮК-ын төлөөлөл бүхий 17 аймагт тус ажлыг хамтран төлөвлөж явууллаа. Хүний эрхийн хамгаалагчийн тухай хэлэлцүүлэг, уулзалт, хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг арга хэмжээнээс гадна орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллав. Уг аяны хүрээнд Комисс 5 удаагийн уулзалтад оролцон тухай бүрт холбогдох ажилтнуудыг мэдээллээр хангаж, холбон зуучлав. Мөн энэхүү өдөрлөгт төлөөллөө оролцуулах албан хүсэлтийг Санамж бичиг, хамтын ажиллагаатай 9 байгууллагад явуулж, тус арга хэмжээнд нийт 90 гаруй хүнийг оролцуулж хамтран ажиллалаа.

2. ДБЭТ-т 10-ны өдөр зохион байгуулсан “Эрхийнхээ төлөө нэгдэцгээ” өдөрлөгийн үеэр Монголын Үндэсний Сонсголгүй иргэдийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан дохионы хэлний 2 хэлмэрчийг ажиллуулав. Тус өдөрлөг арга хэмжээг МҮОНТВ-ийн 1 дүгээр сувгаар 3 цагийн турш шууд дамжуулан орон даяар нэвтрүүллээ.

1. 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хүний эрхийн олон улсын өдөрт зориулсан хэвлэлийн бага хурлыг зохион байгууллаа. Тус хурлыг [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) онлайн тв сайт болон МҮОНТВ-ийн ММ агентлаг шууд сурвалжлан дамжууллаа. Мөн энэ өдөр зохион байгуулсан арга хэмжээнд UBS, SBN, Eagle, MNC, C1, Парламент, Стар, ТВ9, VTV зэрэг 10 гаруй телевиз, [www.news.mn](http://www.news.mn), [www.peak.mn](http://www.peak.mn), [www.ikon.mn](http://www.ikon.mn) зэрэг 20 орчим сайт, өдөр тутмын “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр” зэрэг 5 сонин, МОНЦАМЭ, МҮОНР, Гэр бүлийн радио 104.5 зэрэг нийт 50 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөл оролцож, сурвалжлага, ярилцлага, тодруулга бэлтгэн олон нийтэд хүргэжээ.

2. “Хүний эрхийн Олон Улсын Өдөр-2019” цахим хуудсыг хийж, холбогдох мэдээллийг байршууллаа.

3. Хүний эрхийн өдрийг тохиолдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор МҮОНРТ болон 4 телевизэд хамтран ажиллах албан хүсэлтийг явуулж, ХЭҮК-оос сүүлийн үед хийлгэсэн тв шторкуудыг цацуулахаар илгээлээ. “МУХЭҮК-т хэрхэн гомдол гаргах вэ”, “МУХЭҮК”, “Ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооё”, “Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэе”, “Ажлын байрны бэлгийн дарамтыг үл тэвчье”, “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн харилцаанд тэгш оролцох ёстой”, “Гэгээн нас”, “Хүүхэд зугаа цэнгэлийн золиос биш”, “Зодож биш зааж сургая”, “Хүүхдийн эрхийн зөрчлийг арилгахад миний оролцоо”, “Хүүхдийн оролцоо” шторкуудыг МҮОНТВ-ээр 2019 оны 12 дугаар сарын 09-нөөс 15-ны өдрийг дуустал цацуулав.

2.2.6 Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь аймгуудад "Хүний эрхийн нээлттэй өдөр" зохион байгуулах	Гүйцэтгэлийн хамрах хугацаа											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

2019 оны 4 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Говь-Алтай аймагт, 2019 оны 6 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Дундговь аймагт, 2019 оны 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 5-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай аймагт, 2019 оны 10 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Говьсүмбэр аймагт “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээг Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), эдгээр аймгийн Засаг даргын тамгын газартай (ЗДТГ) хамтран Комиссын үйл ажиллагааг сурталчлах, хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, иргэд, олон нийт, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг хийх, тодорхой байгууллагууд дээр хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгуулах, таслан зогсоох зорилгоор хяналт шалгалтыг зохион байгуулах, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, төрийн байгууллагуудаас нийтээр мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны актуудад дүн шинжилгээ хийх зэрэг цогц арга хэмжээг зохион байгууллаа.

<b>2.2.7 “Нээлттэй сургууль” сонины “Хүний эрхийн боловсрол” буланд мэдээлэл нийтлүүлэх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Комисс “Нээлттэй сургууль” сонинд дараах хуваарийн дагуу булан ажиллуулав.

1 сар	2 сар	3 сар	4 сар
“ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр хийсэн ярилцлага, “Нэр төр алдар хүндээ хамгаалуулах эрх” нэр томъёоны тайлбар, “Надад асуулт байна” зэрэг сэдвээр нийтлэл	“Гэр бүл дэх хүний эрх” сэдвээр нийтлэл, “Хүний эрхийн хамгаалагч” нэр томъёоны тайлбар, “Надад асуулт байна – Сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдвөл ямар хариуцлага тооцдог вэ?” зэрэг сэдвээр мэдээлэл	. “Хүүхэд хэн нэгний өмч биш” сэдэвт ярилцлага, “Нэртэй байх эрх” нэр томъёоны тайлбар, “Надад асуулт байна – Гэр бүл салсан тохиолдолд хүүхдийн өмнө хүлээх хариуцлага буурах уу?” зэрэг сэдвээр мэдээлэл	“Хүний эрхийн боловсрол” нийтлэл, “Гэм буруугүйд тооцох эрх” нэр томъёоны тайлбар, “Надад асуулт байна – Эрх нь зөрчигдсөн талаар хүүхэд өөрөө гомдол гаргах боломжтой юу?” зэрэг сэдвээр мэдээлэл
5 сар	6 сар	7 сар	8 сар
“Хүний эрхийн далд хэлбэрийн зөрчил болох гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооё” нийтлэл	“Материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрх” нэр томъёоны тайлбар, “Надад асуулт байна – Эрх нь зөрчигдсөн талаар хүүхэд өөрөө гомдол гаргах боломжтой юу?” зэрэг сэдвээр мэдээлэл	Дугаар хэвлэгдээгүй.	“Хэрхэн хүний эрхэд ээлтэй сургууль болох вэ”, “Хүний эрхэд ээлтэй сургуулийн шалгуур үзүүлэлт, зарчмууд”, “Шилжин суурьших эрх” сэдвээр нийтлэл
9 сар	10 сар	11 сар	12 сар
“Хүүхдийн эрхийн асуудлаар хэн, ямар даалгавар авсан бэ?”, “Эрхийг хангах баталгаа” сэдвээр	“Хүний эрхэд ээлтэй сургуулиудад ямар өөрчлөлт гарав”, “Монгол Улс дахь гэр бүлийн хэлбэрүүд”	“Хүний эрхийн зөрчлийг эрх зүйн зөрчлөөс ялгах нь” сэдвээр нийтлэл	ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж “Цахим ертөнцөөр хүний нэр төрийг зохиомлоор, зохион

нийтлэл	сэдвээр нийтлэл	байгуулалттайгаар гутаадаг, гүтгэдэг, хохироодог асуудлыг шийдэх цаг болсон” ярилцлага
---------	-----------------	--

<b>2.2.8 Комиссын цахим сайт, Facebook, YouTube хуудас, сурталчилгааны самбаруудыг тогтмол шинэчлэх, монгол, англи хэл дээр хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу Комиссын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хэвлэлийн мэдээг 2019 онд дараах байдлаар бэлтгэж байршууллаа.

Огноо /сараар/	nhrcm.gov.mn цахим хуудас				Комиссын FB хуудас	
	Монгол хэл дээр	Англи хэл дээр	Орон нутгийн ажилтнуудын оруулсан мэдээ	Цахим хуудаст нэвтэрсэн тоо	FB хуудас дахь Like дарсан хүмүүсийн тоо	Мэдээллийг үзсэн хүмүүсийн тоо давхардсан тоогоор
1	12	1	22	530	9,531	49,613
2	8	-	16	92	9,678	12,764
3	12	-	34	442	9,804	27,692
4	15	-	-	460	10,139	67,000
5	22	2	26	435	10,349	75,000
6	15	1	13	321	10,454	60,000 <sup>1</sup>
7-8	-	-	6	90 гаруй	10,510	10,000 гаруй
9	16	3	6	120	10,848	44,991
10	13	2	10	180 орчим	11,000	50,000
11	14	3	28	200 орчим	11,040	45,000
12	15	-	34	300	11,651	70,000

Комиссын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Комиссын дарга, гишүүн, Ажлын албаны ажилтнууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 1 сард 20, 2 сард 30, 3 сард 40, 4 сард 39, 5 сард 29, 6 сард 40 удаа, 7-8 сард 10 гаруй удаа, 9 сард 20 орчим удаа, 10 сард 20 гаруй удаа, 20 гаруй удаа, 11 дүгээр сард 28, 12 дугаар сард 45 мэдээ мэдээлэл өгч хамтран ажиллалаа.

<b>2.2.9 МҮОНТ-тэй хамтран “Хүний эрхийн булан” нэвтрүүлэг бэлтгэж түгээх</b>	<b>Гүйцэтгэлийн хамрах хугацаа</b>											
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>

Энэхүү нэвтрүүлгийг бэлтгэж түгээгээгүй болно.

### Нэмэлт. “Далай Ээж” Эко-Соёлын Аян- 2019 олон улсын арга хэмжээг зохион байгуулахад оролцох

Монгол орны цэвэр усны нөөцийн 74 хувь, дэлхийн цэвэр усны нөөцийн 0.2 хувийг дангаараа бүрдүүлдэг Хөвсгөл нуурыг НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэлхийн байгалийн өвд бүртгүүлэх ажлыг сурталчлан, дэмжих зорилготой “Далай Ээж” Эко-



Соёлын Аян- 2019 олон улсын арга хэмжээг байгаль хамгаалал, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 төрийн бус байгууллага санаачилан 7 дугаар сарын 4-19-ний өдрүүдэд зохион байгуулахад Комисс хамтран оролцов. Хөвсгөл нуурыг хамгаалахтай холбоотой энэхүү эко соёлын аянд 9 орны 50 уран бүтээлчид хөгжимчид дуучид, зураачид, сэтгүүлч, хуульчид, байгаль орчны идэвхтэн судлаачид хамтран ажиллав. Эко соёлын аян 14 хоногийн туршид үргэлжилж, Улаанбаатар Эрдэнэт Хөвсгөл Хатгал гэсэн маршрутаар ажилласан болно. 2019 оны 7 дугаар сарын 8-ны өдөр “Усны эрх-хүний эрх:Хөвсгөл нуурын хамгаалал” олон улсын эрдэм шинжилгээний хурал “Холидэй Инн” зочид буудлын 19 давхрын хурлын танхимд болсон бөгөөд тус хуралд Комиссын дарга “Усны эрх ба хүний эрх” илтгэлийг тавьж, уг илтгэлийг Комиссын цахим хуудаст байршуулан нийтийн хүртээл болголоо. Тус хуралд нийт 70 гаруй оролцогчтой байлаа. Энэхүү эко соёлын аяны сурталчилгаа мэдээллийн брошур, хөтөлбөрийг хянах, Далай ээж олон улсын хөгжмийн үдэш арга хэмжээний билетийн борлуулалтыг хийх зэрэг бэлтгэл ажилд хамтран оролцож, ажиллав. Мөн тус төслийн хүрээнд Хатгал тосгоны дунд сургууль болон Соёлын төвийг зурж, чимэглэх, Хөвсгөл далайн боомт болон Соёлын төвд зохион байгуулах урлаг соёлын тоглолт, галын наадам зэрэг үйл ажиллагааны бэлтгэл ажилд Комиссын ажилтнуудаас бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын ажлын хэсэг 2019 оны 7 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд ажиллаж, тус арга хэмжээний бэлтгэл ажлыг хангахад хамтран оролцож ажиллалаа.

**Нэмэлт.** Хүүхдийн Эрхийн тухай конвенц батлагдсаны 30 жилийн ойн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Гүүд Нейборс ОУТББ-ын гаргасан санал санаачилгын дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамтай хамтран “Хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах нь” хэлэлцүүлгийг зохион байгуулав. Уг хэлэлцүүлгийн зорилго Хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх, хамгаалах талаар зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалтын талаар санал солилцож, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай болон Эрүүгийн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахад чиглэсэн саналын төсөл боловсруулан холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдад өргөн барихад чиглэсэн бөгөөд хөтөлбөрийн дагуу Комиссын дарга хэлэлцүүлгийг нээж үг хэлсэн бол Ахлах референт З.Өнөржаргал Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилт, цаашид сайжруулах талаар модератор хийж, санал солилцов. Уг хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг Ахлах референт Ц.Адъяахишиг хангаж ажиллахын зэрэгцээ хэлэлцүүлгийн нээлтэд Комиссын даргын хэлэх үгийг бэлтгэсэн болно. Хэлэлцүүлгийн үр дүнд ХЭҮК, Гүүд Нейборс ОУТББ-тай хамтран Хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох хуулиудад саналаа гарган УИХ-д хүргүүлэхээр болов.

### **Нэмэлт. Тэгш нийгэм ТББ-ын орон нутгийн салбар зөвлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулах**

"Тэгш нийгэм холбоо" ТББ-ын орон нутгийн салбар зөвлөлийн ажилтнуудад 2019 оны 6 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хамтрагч байгууллагаас санал авч сургалтын хөтөлбөрийг эцэслэн батлуулах, сургалтад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг таньж илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох сэдвээр хэлэлцүүлэг хийх зэрэг ажлыг гүйцэтгэв.

**Нэмэлт.** “Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан танилцуулах уулзалт зохион байгуулах

Уулзалтыг 4 дүгээр сард зохион байгуулж холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг хийв. Уулзалтад НҮБХАС-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч, Комиссын дарга тэргүүтэй хүмүүс оролцов.

### **Нэмэлт. “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо”-ны аянд хамтран оролцох**

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооноос “Бос, Гэрэлт-эмэгтэйчүүд, хүүхдүүдийг дэмжих аян”-ыг 2019 оны 3 дугаар сарын 4-30 өдрүүдэд Сэлэнгэ, Ховд, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Хэнтий, Дорноговь, Өвөрхангай аймгуудад нийт 2500 хүүхэд эмэгтэйчүүдийг хамруулан зохион байгуулав. Тус аянд Дундговь, Баян-Өлгий, Сэлэнгэ, Архангай, Хэнтий, Увс гэсэн зургаан аймаг дахь орон нутгийн ажилтнууд оролцож Хүний эрх, Жендэрийн тэгш байдал ба түүний ач холбогдол, Хүүхдийн эрх сэдвээр сургалт хийв.

### **Нэмэлт. Хууль зүйн их, дээд сургуулиудад хүний эрхийн сэдвээр хичээл зааж буй багш нарын дунд туршлага солилцох уулзалт зохион байгуулах**

Уулзалтыг хөтөлбөрийн дагуу 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдөр “Бишрэлт” зочид буудалд зохион байгуулав. Уг уулзалтад эрх зүйч бэлтгэж буй хууль зүйн их, дээд сургуулийн багш нар оролцож, санал бодлоо солилцов. Мөн уулзалтын үеэр Комиссын хүний эрхийн боловсролын чиглэлээр бэлтгэж хэвлүүлсэн ном товхимол, гарын авлагаар бичил үзэсгэлэн гаргав.

## **ГУРАВ: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **3.1.2 Хүний эрхийг хамгаалагчдын тухай хуулийн төслийн хүрээнд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах**

Хүний эрхийн хамгаалагчийн асуудлаарх нөлөөллийн ажлын хүрээнд ажлын хэсгийн гишүүдтэй нийт 2 удаагийн уулзалт зохион байгуулж тогтмол харилцаатай ажиллаж байна. Уулзалтаар хуулийн төслийг урагшлуулах талаарх нөлөөллийн арга хэмжээ болон хүний эрхийн хамгаалагчийн асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч Монгол улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбоотой асуудлаар гишүүд тус тус санал солилцсон болно. Энэ ажлын хүрээнд ажлын хэсгийн гишүүдтэй хамтран хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой бүхий л шаардлагатай материалыг бүрдүүлж хууль санаачлагч гишүүн, Гадаад хэргийн сайд Д.Цогтбаатарт хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “хуулийн төслийг дэмжих боломжгүй, цаашид хуулийн төсөлд тусгасан асуудлыг одоо мөрдөж буй хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулах боломжийг судалж үзэх нь зүйтэй байна” гэсэн тогтоол гаргасан. Уг тогтоолыг ажлын хэсгийн гишүүдэд тус бүр танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүд хуулийн төсөлд зарчмын өөрчлөлт оруулах шаардлагагүй, цаашид нөлөөллийн ажлыг хийх нь зүйтэй байна гэж үзсэн. Гадаад хэргийн сайдын зөвлөх Энхтуяа тогтоолд заасан үндэслэлийн дагуу техникийн зарим нэг өөрчлөлт оруулах саналыг тавьсаны дагуу хуулийн төслийг холбогдох материалын хамт хүргүүлээд байна. Мөн тусгай илтгэгчтэй ажлын хэсгийн гишүүд уулзаж, хуулийн төслийн үндсэн агуулга, Монгол дахь хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдал, өөрсдийн хийж хэрэгжүүлсэн ажлыг танилцуулж мэдээлэл өгч ажилласан. Түүнчлэн хуулийн төслийн талаар хүний эрхийн хамгаалагчдад мэдээлэл хүргүүлэх, тэдний

дэмжлэгийг авах ажлыг ажлын хэсгийн гишүүд тус бүрдээ зохион байгуулж ажиллав.

Хүний эрхийн хамгаалагчдын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай Илтгэгч Мишел Форст МУ-д айлчлал хийж, Комиссын дарга тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзалт хийсэн. Уулзалтын мөрөөр авах арга хэмжээний хүрээнд, Тусгай илтгэгчийн зүгээс НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд хүргүүлэх тайланд тусгуулах хүсэлт бүхий хоёр өгүүлбэрийг англи хэл дээр боловсруулж цааш хүргүүлсэн. Үүнд Хүний эрхийн хамгаалагчдын тухай хуулийн төслийг батлахыг дэмжих тухай, нөгөө нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхийг бэхжүүлэх тухай өгүүлбэр орсон.

Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулийн төслийн талаар хийх нөлөөллийн ажлын хүрээнд ГХЯ, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийг оролцуулан 9 дүгээр сарын 4-ний өдөр зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. Уулзалтад холбогдох яамд, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, судлаач нийт 50 хүн оролцов. Мөн 9 дүгээр сарын 4-ний өдрийн 18.00-20.00 цагт Нээлттэй Нийгэм Форум, Эмнести Интернешнл байгууллагын хамтран зохион байгуулсан кино үдэшлэг арга хэмжээний талаар сурталчлах, түгээх ажлыг зохион байгуулав. 9 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулсан олон нийтийн цуврал лекц арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Тусгай илтгэгчид синхрон орчуулга хийх орчуулагч, орчуулгын төхөөрөмжийг олж зохион байгуулалтыг хангав.

### ***3.1.3 “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төслийг хэрэгжүүлэх***

Энэхүү ажлын хүрээнд Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал төслийн хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 26-наас 27-ны өдрүүдэд “Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ семинар”-ыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Шведийн Байгаль орчныг хамгаалах агентлаг, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан.

Комисс нь Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ семинарын хүрээнд нийт оролцогчдыг 12 ширээнд хуваарилж бүлгээр ажиллуулах явцад “Жендэр” болон “Хороо ажлаа төлөвлөх, тайлагнах, мэдээлэх” сэдвийг хэлэлцэж буй ширээнүүдэд чиглүүлэгчээр ажилласан болно. Тус арга хэмжээнд гадаадын экспертүүдээс гадна төрийн болон байгаль орчны иргэний нийгмийн байгууллагууд, Төв, Булган, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь аймгийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байцаагч нар, иргэдийн төлөөлөл 100 гаруй хүн оролцсон байна.

### ***3.1.4 Бизнес ба хүний эрхийн талаарх үндэсний Хөтөлбөр боловсруулах, санал авах нөлөөллийн ажлууд зохион байгуулах***

Бизнес ба хүний эрхийн талаарх үндэсний Хөтөлбөр боловсруулах талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Сайн дурын сангаас хэрэгжүүлж буй төслийн нэг дэд хэсэг орсон бөгөөд тус төслийн дэд хэсгийн санхүүжилтээр 2019 оны 6 дугаар сард ГХЯ холбогдох бүх талыг оролцуулан зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Үндэсний хөтөлбөр боловсруулах Ажлын хэсгийг Гадаад харилцааны сайдын тушаалаар байгуулсан болно.

### **3.1.5 Икуал Райтс Траст байгууллагатай хамтран ялгаварлан гадуурхалт, тэгш эрхийн асуудлаарх тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулах**

Уг ажлын хүрээнд Икуал Райтс Траст байгууллагын /ИРТ/ тэтгэлэгт хамрагдах хүсэлт бүхий нийт 26 газраас төслийн санал ирүүлсэн бөгөөд Сонгон шалгаруулах хороо болон Икуал Райтс Траст байгууллагаас өндөр оноо авсан 5 газрыг урьдчилсан байдлаар шалгаруулж, GPS+ өргөн хүрээний төслийн зорилттой нийцүүлэх шаардлага тавьсны үндсэн дээр шалгарсан байгууллагуудтай уулзаж төслийн саналаа дахин засварлаж, шинэчлэх хүсэлтийг тавьсан. Үүний дараа шинэчилж ирүүлсэн төслийн саналыг орчуулж цааш хүргүүлсэн бөгөөд Икуал Райтс Траст байгууллагаас шинэчилсэн 5 төслийн саналыг хянаж, шалгаруулалтын эцсийн хариуг 1 сарын 25-ны өдөр ирүүлсэн. Шалгарсан байгууллагуудтай байгуулах гэрээний загварыг Икуал Райтс Траст байгууллагаас хүлээн авсаны үндсэн дээр шалгарсан 4 байгууллагатай санхүүжүүлэгч байгууллага хооронд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан. Байгууллагууд төслөө 2 сарын сүүл, 3 сарын эхээр хэрэгжүүлж эхэлсэн ба сар бүрийн үйл ажиллагааны тайлан болон улирлын санхүүгийн тайланг хүлээн авч, хянаж, орчуулж, ИРТ-д хүргүүлж, тухай бүрт холбогдох талуудтай утсаар болон имейлээр харилцаж байна.

Европын Холбооны логог ашиглах зааварчилгааг орчуулж 4 байгууллага тус бүрлүү имейлээр хүргүүлсэн болно. Тува Ээж, Үндсэн Уртраг ТББ-уудын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг англи хэл рүү орчуулах, төслийн хүрээнд ашиглах гарын авлага зэрэг материалыг англиас монгол хэл рүү орчуулж өгөв. ИРТ-аас санал болгосны дагуу Тува Ээж, Үндсэн Уртраг ТББ-ууд ИРТ-тэй хамтарч НҮБ-ын Арьс өнгөний ялгаварлан гадуурхалтын устгах Хороонд сүүдэр илтгэл бичих болсон тул, Комиссоос Тува Ээж, Үндсэн Уртраг ТББ-уудад техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор ИРТ-ээс ирүүлсэн илтгэлд оруулах мэдээллийн зааврыг орчуулж дээрх 2 ТББ-д хүргүүлсэн болно. Иилтгэлд оруулах мэдээлэл ирмэгц түүнийг нь орчуулж ИРТ-рүү хүргүүлнэ.

ИРТ-ын хөтөлбөрийн ажилтан Улаанбаатар хотод ирж 7 сарын 4,5-ны өдрүүдэд Тэгш эрх болон үл ялгаварлан гадуурхалтын сэдвийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах болсон тул сургалт явуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Тухайлбал, дээрх хөтөлбөрийн ажилтан виз авахад шаардагдах албан бичгийг боловсруулж, гадаад иргэнийг урих мэдүүлэгийн хамтаар ГХЯ-ны Консулын газарт хүргүүлэв. Мөн сургалтын байр, хоолыг захиалж, синхрон орчуулга хийх орчуулагчийг олох, орчуулгын тоног төхөөрөмж түрээслэх байгууллагатай холбогдож захиалгыг өгсөн болно. Түүнчлэн, сургалтын материалыг англиас монгол хэл рүү орчуулах ажлыг хийв.

## **ДӨРӨВ: ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **4.1 Гадаад хамтын ажиллагаа**

#### **4.1.2 ХЭҮБДХ-ны 32 дугаар хуралд Комиссын төлөөлөл оролцох ажлын бэлтгэл хангах**

Комиссын төлөөлөл ХЭҮБДХ-ны хуралд оролцов. Томилолтын бэлтгэл ажлын хүрээнд ХЭҮБДХ-ны онлайн сүлжээнд бүртгүүлэх, гадаад томилолтын тушаалын төсөл боловсруулж, аяллын даатгал хийлгүүлэх, ажилтнуудын визний материал бүрдүүлэх, Женев болон Берлин дэх ЭСЯ-нд хүргүүлэх албан бичгийн төсөл боловсруулж, цааш хүргүүлэх, УИХ-ын даргаас захирамж хүссэн албан захидал боловсруулах, хурлын хөтөлбөр орчуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

Ч.Алтангэрэл даргын боловсруулсан илтгэх хуудсыг УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст хүргүүлэв.

Ажлын албаны дарга АНДЧ-ны Ажлын албаны дарга нарын хуралд хуралд оролцохтой холбогдуулж гадаад томилолтын тушаалын төсөл боловсруулж, аяллын даатгал хийлгүүлэв. Комиссын дарга дээрх хуралд оролцохтой холбогдуулж дараах бэлтгэл ажлыг хангав. Үүнд: Комиссын дарга гадаадад томилолтоор ажиллахтай холбогдуулж УИХ-ын даргаас захирамж хүссэн тухай албан бичгийн төсөл боловсруулах, хуралд тавих Комиссын даргын илтгэлийн паур пойнт танилцуулга бэлдэх, БНСУ дахь ЭСЯ-наас техникийн туслалцаа хүссэн албан бичиг боловсруулж, хүргүүлэх, АНДЧ-ны даргын мэдэгдлийг орчуулах, аяллын даатгал хийлгэж, хурлаас ирсний дараа илтгэх хуудсын төсөл боловсруулж, хянуулж, УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцаанд хүргүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

#### **4.1.3 НҮБ-ын ХЭДКГ, АНДЧ, ХЭҮБДХ зэрэг олон улсын байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх**

Энэхүү ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг 2019 онд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. АНДЧ-наас ХЭҮБ-уудад хандаж НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын тухай Комиссын 63 дахь удаагийн чуулган Нью-Йорк хотноо 2019 оны 3 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд болох гэж байгаатай холбогдуулан тус Комиссын Нэгдсэн Дүгнэлт (Agreed Conclusions)-д ХЭҮБ-уудыг охид, эмэгтэйчүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиг үүрэг бүхий үндэсний бие даасан байгууллага болохыг хүлээн зөвшөөрсөн агуулга бүхий хэсгийг оруулахыг зорьж байгаа бөгөөд ХЭҮБ-уудыг өөрсдийн засгийн газартаа хандаж, нөлөөллийн ажил явуулахыг уриалсан. Энэ хүрээнд Комиссын даргад асуудлыг танилцуулж, албан бичиг төлөвлөж ГХЯ болон ХНХЯ-д хүргүүлсэн. Үүний үр дүнд ГХЯ-наас Нью-Йорк хотод суугаа Байнгын төлөөлөгчийн газарт дээрх агуулгыг оруулж, Засгийн газрын зүгээс дэмжсэн байр сууриа илэрхийлэх чиглэл өгсөн болохыг ГХЯ-наас мэдэгдсэн.

2. Ардчиллын Хамтын Нийгэмлэг, Азийн Хөгжлийн Холбоо, Азийн Ардчиллын Сүлжээнээс Улаанбаатар Ардчиллын Форумыг 2019 оны 2 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд Комиссын даргын нээлтийн хэлэх үгийг боловсруулав.

3. Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настны эрхийг хариуцсан НҮБ-ын Тусгай Илтгэгчээс ирүүлсэн санал асуулгад хариулт өгсөн бөгөөд тус хариултыг англи хэл рүү орчуулж /3 хуудас/ цааш хүргүүлэв.

4. НҮБ-ын Ахмад настны асуудал хариуцсан Ажлын хэсгээс ХЭҮБ-уудад хандаж ирүүлсэн Ахмад настны боловсрол, сургалт, насан туршийн боловсрол болон тэдний хөдөлмөрлөх эрхийн асуудлаарх санал асуулгын хариултыг ахлах референт 3.Өнөржаргал боловсруулсан бөгөөд хариулт 8 хуудас материалыг орчуулж цааш 10 сарын 31-нд хүргүүлсэн болно.

5. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт Комиссоос хөндлөнгийн илтгэл хүргүүлэх ажлын хүрээнд Австралийн сайн дурын ажилтан Лаураг холбогдох мэдээллээр хангаж, түүний боловсруулсан илтгэлийн төсөл дээр Комиссын дарга болон бусад хэлтсийн дарга нарын саналыг авч, нэмэлт мэдээллийг англи хэл дээр орчуулж, 10 сарын 3-ны өдөр UPR-ийн

цахим системд оруулав. Мөн монгол хувилбар дээр нэмэлт мэдээллийг оруулж, абле сүлжээнд тус илтгэлийг англи болон монгол хэл дээр оруулсан болно.

6. Австралийн сайн дурын хөтөлбөрөөс сайн дурын ажилтан Комисс дээр авч ажиллуулах хүсэлт, шаардлагын дагуу ЛГБТ Төв дээр ажиллахаар ирсэн сайн дурын ажилтан Лаураг Комисс дээр 7 хоногт 1-2 хоног ажиллуулсан бөгөөд тэрээр Комиссын 18 дахь илтгэлийн англи хэл дээрх хувилбарыг хянах, ЕХ-нд хүргүүлсэн төслийн бүтэн саналыг боловсруулах, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт ХЭҮБ-ын илтгэл боловсруулах ажилд техникийн туслалцаа үзүүлэв.

Иймд ирэх жил буюу 2020 онд Комисс дээр Австралийн сайн дурын ажилтан авч ажиллуулах хөтөлбөрт хамрагдах өргөдлийг бөглөж, цааш холбогдох байгууллагад хүргүүлсэн ба зар нь цахим хуудсанд тавигдсан болно.

7. Малайз Улсад амиа алдсан иргэний шүүх хуралд Комиссын гишүүн П.Оюунчимэг оролцох бэлтгэл ажлыг хангах хүрээнд Малайз улсад хүний амь нас хохироосон хохирлыг хэрхэн барагдуулдаг талаарх мэдээлэл цуглуулах, эрүүгийн болон иргэний тухай үндэсний хууль тогтоомж болон Малайз улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ конвенцыг судлах, АНДЧ болон Малайзын ХЭҮК-оос дээрх асуудлаар техникийн туслалцаа хүссэн албан захидал явуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

8. Комиссын гишүүн П.Оюунчимэг БНСУ-ын Бусан хотноо болох “Ардчилал – хүний эрхийн форум”-д оролцох бэлтгэл ажлыг хангах хүрээнд тус форумд бүртгүүлж /2 хуудас материал англи хэл дээр боловсруулж/, гадаад томилолтын тушаал боловсруулж, гишүүний товч намтарыг англи хэл дээр боловсруулах, онгоцны билетийг захиалах ажлыг хийж гүйцэтгэв. Мөн хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжихэд ХЭҮК-ын үүрэг оролцоо, үйл ажиллагааны талаарх 2 хуудас бүхий танилцуулгыг англи хэл дээр боловсруулав.

9. "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд Бүгд Найрамдах Финлянд Улсын Хелсинки хотноо 2019 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд болох “Жендэр судлал 2019: Хүчирхийлэл” сэдэвт олон улсын бага хуралд Комиссын гишүүн П.Оюунчимэг, хэлстийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцох, 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Шведийн Вант Улсын Хөдөлмөрийн яамны холбогдох хүмүүстэй Комиссын гишүүн П.Оюунчимэг жендэрийн асуудлаар туршлага солилцох уулзалт, Швед улсад ажиллаж, амьдарч буй Монголчуудын төлөөлөлтэй уулзах уулзалтыг зохион байгуулах ажлын хүрээнд ГХЯ-ны Европын Газарт албан бичиг хүргүүлж, Швед дэх ЭСЯ-наас Комиссын гишүүнийг угтах, үдэх ажлыг зохион байгуулах асуудлаар холбогдов. Мөн Швед улсын Хөдөлмөрийн яамны холбогдох хүмүүстэй имейлээр харилцаж уулзах уулзалтын товыг гаргах, гадаад томилолтын тушаалын төсөл боловсруулах, жендэрийн асуудлаар 1 хуудас мэдээлэл англи хэл дээр боловсруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

10. Комиссын дарга Ж.Бямбадорж Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба улсын Катманду хотод 2019 оны 11 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд болох Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын бага хуралд оролцох бэлтгэл ажлын хүрээнд Комиссын даргыг тус хуралд бүртгүүлэх, УИХ-ын даргаас захирамж хүссэн албан бичгийн төсөл боловсруулах, гадаад томилолтын тушаал боловсруулах, хурлын үеэр Комиссын даргын тавих мэдээллийг монгол болон англи хэл дээр боловсруулах /тус бүр 2 хуудас/, хурлын хөтөлбөр /8 хуудас/ орчуулах болон аяллын даатгал хийлгүүлэх ажлыг хийж

гүйцэтгэв. Мөн Комиссын дарга уг хуралд оролцсон тухай илтгэх хуудсын төсөл /2 хуудас/ боловсруулж, хянуулж УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст хүргүүлэв.

#### **4.1.4 Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал, сургалт семинарт ажилтнуудыг хамруулах, зохих бэлтгэлийг хангах**

1. Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбоо, Фридрих Эбертийн Сан, Хүний эрхийн Дээд Комиссарын Газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сургалт, Судалгааны Хүрээлэнгээс ШХУ-ын Женев хотод 2019 оны 5 дугаар сарын 6-10-ны өдрүүдэд “Хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан олон улсын хүний эрхийн механизм” сэдэвт сургалтад Комиссын референт Э.Мөнхзул оролцов.
2. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас жил бүр зохион байгуулдаг ХЭҮБ Академи 2019 сургалтад хамрагдах референт Т.Ариунаа оролцов.
3. БНСУ-ны ХЭҮК-оос зохион байгуулах ХЭҮБ-уудын Түншлэл 2019 хөтөлбөрт хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ оролцов.
4. АНДЧ Харилцааны холбооны сүлжээний сургалтыг АНДЧ-тай хамтарч ХЭҮК Улаанбаатар хотод 2019 оны 8 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулах болсон бөгөөд Комиссоос дээр сургалтад референт З.Бадмаараг, Т.Ариунаа, түр орлон гүйцэтгэгч Э.Зул нар оролцох болсон бөгөөд референт З.Бадмаараг, Т.Ариунаа нарыг дээрх сургалтад бүртгүүлэв.
5. Дээр дурдсан Икуал Райтс Траст байгууллагаас Улаанбаатар хотод 2019 оны 7 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулах сургагч багшийн сургалтад Комиссоос референт Х.Цэцгээ, Х.Мөнхзул, С.Сайханжаргал нар оролцов.

#### **4.1.5 ХЭҮБДХ-ны магадлан итгэмжлэлд хамрагдах**

ХЭҮК-ийн тухай хуулийн төсөл хараахан батлагдаагүй байгаа тул магадлан итгэмжлэлд орох хуваарийг 1 жилээр хойшлуулах хүсэлт Комиссоос явуулсан бөгөөд Дэд хорооноос уг хүсэлтийг хүлээн авч, 1 жилээр хойшлуулсан болно.

#### **4.1.6 Хүний эрхийн чиглэлээр төслийн санал боловсруулж, тэтгэлэг олгогч байгууллагуудад хүргүүлэх**

2019 онд Комиссын ажилтнууд дараахь төслийн саналуудыг боловсруулж, хүргүүлсэн байна. Үүнд:

1. Канадын сангаас төслийн тэтгэлэг зарласантай холбогдуулж, Комиссын ажилтнууд хамтарч “Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх багц цагийн сургалт зохион байгуулах, мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн сургалт оруулах нь” сэдэвт төслийн санал боловсуулсан бөгөөд төслийн хураангуйг орчуулж цааш хүргүүлсэн боловч шалгараагүй болно.
2. Австралийн ЭСЯ-наас зарлагдсан тэтгэлгийн дагуу “Их сургуулиудад хүний эрхийн боловсролыг түгээх замаар ялгаварлан гадуурхалтыг арилгах нь” сэдэвт төслийн саналыг боловсруулж байгаа бөгөөд 4 сарын 30-нд төслийн санал хүргүүлсэн ч тэнцээгүй.

3. АНДЧ-ны Харилцаа холбооны сүлжээний гишүүдийн дунд зарлагдсан дижитал түүх бүтээх төслийн уралдаанд референт Т.Ариунаа шалгарч 2,000 Австрали долларын тэтгэлэг авч, энэ хүрээнд шаардагдах зургийн камер, дагалдах хэрэгслийн худалдан авалт хийж, дижитал түүх бүтээхэд бэлэн болов. Өмнөговь, Баянхонгор аймагт судалгаагаар явсан баг видео бичлэг хийхээр болсон бөгөөд тэдний дарсан зураг, бичсэн видеог монтажлаж цааш АНДЧ-нд 8 дугаар сарын 20-ны дотор хүргүүлэв.

4. Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо (МЭХ) Комисст санал тавьсны дараа Европын Холбооноос зарлаж буй тэтгэлэгт төслийн санал хамтран хүргүүлэхээр болов. Энэ хүрээнд Комиссоос Т.Ариунаа оролцож МЭХ дээр 3 өдөр ажиллаж, МЭХ-ноос оруулсан холбогдох мэдээллийг орчуулж, төслийн саналыг англи хэл дээр боловсруулж онлайн-ар хүргүүлсэн бөгөөд эхний шатанд шалгарсан тул дараагийн шатны төслийн дэлгэрэнгүй саналыг Т.Ариунаа, сайн дурын ажилтан Лауратай хамтран боловсруулж, хүргүүлэв. Уг төслийн саналд Комиссын санхүүгийн сүүлийн 3 жилийн тайлангийн дүгнэлт орчуулах, МЭХ-ноос холбогдох мэдээллийг авч орчуулав. Төсөл шалгарч ЕХ-ноос нийт 245,000 Еврогийн санхүүжилт авахаар болов. Төсөлд шалгарсан байгууллагуудад батламж гардуулах ёслолд оролцож уг төслийн талаарх 10 минут танилцуулга хийв. Тайланд улсад суугаа Европын Холбооны төлөөлөгчийн газраас ирүүлсэн 3 хувь төслийн эх баримт бичигт Комиссын дарга Ж.Бямбадорж гарын үсэг зурснаас 2 эх хувийг нь Тайланд улс дахь ЕХ-ны Төлөөлөгчийн Газарт буухиа шуудангаар 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлэв.

## **4.2 Дотоод хамтын ажиллагаа**

### **4.2.1 Орон тооны бус зөвлөлийн хурал зохион байгуулах**

Комисс орон тооны гишүүдийн санал санаачлагыг дэмжиж үйл ажиллагаандаа татан оролцуулахад анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд орон тооны бус зөвлөлийн гишүүдийн санаачлагаар ГБХЗГ-ын Нарт хангай төвийн хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах чиглэлээр тус төвийн үйл ажиллагаатай танилцаж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн орон тооны бус зөвлөлийн хурлыг 2019 оны 2 сарын 22 ны өдөр хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад зохион байгуулж, зөвлөлийн гишүүдийн санаачлагаар хэрэгжүүлсэн Сургалт-Хүмүүжлийн тусгай байгууллага” -ын үйл ажиллагаа болон хүмүүжиж буй хүүхдийн нөхцөл байдалтай танилцсаны” дагуу хийсэн “хууль зөрчсөн хүүхдийн нийгэмшүүлэх үйлчилгээнд хийсэн үнэлгээ”-ний дүнг зөвлөлийн гишүүдийн зүгээс тус байгууллагын дарга, алба хаагч нарт танилцуулав. Мөн хурлаар Комиссын 2019 оны төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг гишүүдэд танилцуулж, хамтран ажиллах асуудлаар гишүүдээс санал авч ажилласан. Мөн энэ үеэр ОТБЗ гишүүд болон Комиссын зүгээс хүмүүжигч хүүхдүүдэд зориулсан ном, хичээлийн хэрэгсэл, сагсан бөмбөг, теннис зэрэг хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх спортын хэрэглэгдэхүүнээр сэтгэлийн бэлэг барьсан болно.

Орон тооны бус зөвлөлийн хоёр дахь хурлыг 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав. Орон тооны бус зөвлөлийн тус хурлаар Комиссын 2019 онд явуулсан үйл ажиллагааг дүгнэж, 2020 онд явуулах үйл ажиллагаанд Орон тооны бус зөвлөлөөс өгөх саналыг авав.

### **4.2.2 “ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа” ээлжит уулзалтыг зохион байгуулах**



"ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа" 17 дахь ээлжит уулзалтын бэлтгэл ажлыг ханган 6 дугаар сарын 21-ний өдөр НҮБ-ын байранд зохион байгуулав. Уулзалтыг ХЭҮК-ын 18 дахь илтгэлийг хэлэцээд УИХ-аас гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд зохион байгуулав. Уулзалтын 2 дахь хэсэгт ИНБ-уудыг төлөөлөн "Нээлттэй нийгэм форум" ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Хишигсайхан мэдээлэл хийв.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комисс-Иргэний нийгмийн түншлэл 18 дахь уулзалтыг 12 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулав. Хүний эрхийн Үндэсний Комисс-Иргэний нийгмийн түншлэл 18 дахь уулзалтаар Комиссын 2019 онд хийсэн ажлын онцлох ажлыг танилцуулж, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлд хөндөх асуудлыг хөндөв. Мөн Бодлогод залуусын алхам ТББ-аас ERT ТББ-ын жижиг төслийн дэмжлэгтэй зохион байгуулсан үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, Нээлттэй нийгэм форум ТББ-ын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан иргэний нийгмийн байгууллагуудаас НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд хүргүүлсэн мэдээллийн талаар танилцууллаа.

#### **4.2.3 Монгол Улс дахь олон улсын байгууллагуудтай Хамтын ажиллагааны талаар уулзалт зохион байгуулах**

"Тогтвортой Хөгжлийн Зорилтууд-Хамтын ажиллагаа" зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Комисс дээр зохион байгуулав. Уулзалтын үр дүнд НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраас Комисстой хамтарч Тогтвортой Хөгжлийн Зорилтын талаар чадавхи бэхжүүлэх эсвэл сургалт семинар зэрэг үйл ажиллагааг хамтран зохион байгуулж болох саналыг тавив.

Уг уулзалтын үр дүнд НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газартай Комисс хамтарч ажиллах хүрээнд бусад ХЭҮБ-уудын хийсэн ажлуудыг судалсан бөгөөд ТХЗ-ын асуудлаар постер хийлгэж, тараах ажлыг зохион байгууллаа. Хамтын ажиллагааны талаар хоёр дахь уулзалтыг 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулав.

### **ТАВ: БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **5.1 Комиссыг чадавхижуулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа**

##### **5.1.1 Орон нутгийн ажилтнуудын цугларалт,уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж ажиллах**

2019 онд Комиссын орон нутгийн ажилтнуудын 3 удаагийн цугларалт, сургалт болсон байна. Үүнд: 2019 оны 4 дүгээр сарын 09-12-ны хооронд, 06 дугаар сарын 27-28-ны хооронд тус тус болсон байна. Энэ хүрээнд тэдний Улаанбаатар хотод байх үеийн ажлын төлөвлөгөөг гаргаж, батлуулж, зохион байгуулж, мэдэгдэж ажилласан болно. Мөн эрүү шүүлтийн асуудлаар орон нутагт хийж хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар мэдээлэл цуглуулж нэгтгэн, орон нутгийн ажилтнуудад цаг үеийн асуудлаар Skype ашиглан холбогдож мэдээлэл өгч ажилласан. Хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох мэдээллийг авле-ээр хүргэн ажилласан. 2019 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд болсон цугларалтаар Комиссын дотоодын сургалт зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлыг хийх талаар мэдээлэл хүргэв.

##### **5.1.2. Комиссын ажилтнуудыг чадавхижуулах, ажлын байранд дадлагажуулах, дотоод сургалт зохион байгуулах**

2019 онд Комиссын ажлын албаны ажилтнуудыг ажлын байран дээр нь чадавхижуулах дотоодын сургалтыг нийт 7 удаа зохион байгуулсан байх бөгөөд үүнээс 3 удаад нь орон нутгийн ажилтнуудыг Улаанбаатар хотод ажиллах үеийг тохиолдуулан өргөн хүрээнд зохион байгуулан, хамруулсан байна. Сургалт бүрт сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулж ажилласан болно. Сургалтын дэлгэрэнгүйг дор жагсаавал:

- 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр “Хүний эрхийн индекс ба түүний шалгуур үзүүлэлтүүд” сэдвээр Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн ажилтан Ч.Билгүүн, “Төрийн албан хаагчдын зан төлвийн онцлог” сэдвээр Удирдлагын академийн багш Х.Оюунцэцэг;

- 2019 оны 03 дугаар сарын 07ны өдөр “Төсөл бичих арга зүй” сэдвээр Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн референт Т.Ариунаа, “Угийн бичиг, ургийн баяр” сэдвээр Монголчуудын угийн бичгийн академийн доктор Ш.Биндэрьяа;

- 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн албаны тухай хуулийн хүрээнд батлагдсан журмуудын талаар Төрийн албаны зөвлөлийн ахлах референт н.Амармэнд, н.Зоригтбаатар нар, “Гэр бүлийн харилцаа” сэдвээр Доктор, профессор Т.Намжил, “Баримт бичгийн стандарт, найруулга зүй” сэдвээр Архивын ерөнхий газрын мэргэжилтэн н.Тунгалаг нар;

- 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн талаарх танилцуулга, мэдээлэл” сэдвээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах дэд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, “Гүйцэтгэх засаглал ба Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт” сэдвээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах дэд ажлын хэсгийн гишүүн, Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал О.Машбат, “Өнөөгийн нийгмийн үнэт зүйлс ба төрийн албан хаагчийн цогц чадамж” сэдвээр ХЭҮК-ын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл, “Багийн үйл ажиллагаа: Аж ахуйн жишээн дээр” сэдвээр ХЭҮК-ын референт Б.Мөнх-Эрдэнэ, “Ажлын албаны ажилтнуудын санаачлага, хэрэгжүүлэх төлөвлөгөөний танилцуулга” сэдвээр ХЭҮК-ын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл нар;

- 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр “Гламор” болон “Молар” эмнэлгийн эмч нар ажлын албаны ажилтнуудад амны хөндийн үзлэг болон эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн бол Скайтел компаний ажилтан Н.Хашболд Төрийн албан хаагчдад зориулсан үүрэн телефоны тусгай үйлчилгээний талаар танилцуулга яриа;

- 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр СЭМҮТ-ийн эмч н.Гантулга “Сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүстэй харилцах арга, сэтгэлзүйн тогтвортой байдлаа хангах нь” сэдвээр;

- 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Стресс менежмент” СЭМҮТ-ийн эмч н.Гантулга, “Абле цахим оффисийн хэрэглээний талаар” Абле-ийн ажилтан н.Үржинханд, “Захиргааны хэм хэмжээний актын зохицуулалтын асуудал” сэдвээр ХЗДХЯ-ны Ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ, “Байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” сэдвээр “Ухаалаг засаглал” ТББ-ын тэргүүн н.Амарбаясгалан, “Монголын Төрт ёсны түүх” сэдвээр ХЭҮК-ын референт Г.Ууганбаатар нар тус тус сургалт хийв.

## **5.2 Комиссын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа**

### **5.2.1 Орон нутгийн ажилтнууд үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлтийн талаарх мэдээллийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлэх**

Орон нутгийн ажилтнууд хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангаа нэгдсэн байдлаар ирүүлсэн байна. Комиссын

менежерүүдийн хурлаар орон нутгийн ажилтнуудын тайлан, төлөвлөлт, ажлын гүйцэтгэлийг сайжруулах асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж, энэ талаар орон нутгийн ажилтнуудад мэдээлэв. Анхаарал татсан ажилтнуудад ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах асуудлаар утсаар болон абле-ээр харилцан ажиллаж байна.

### **5.2.2 Комиссын хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэрийг баталгаажуулах**

2019 онд Комиссын хурлыг 14 удаа зохион байгуулсан байна. Үүнд:

- 2019.01.03 (Цаг үеийн асуудлаар)
- 2019.01.07 (Жилийн болон сарын төлөвлөгөө хэлэлцэх, батлах)
- 2019.02.02 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.02.28 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.03.29 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.04.30 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.06.04 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.07.04 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.08.30 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.09.27 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.11.01 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)
- 2019.11.01 (Цаг үеийн асуудлаар)
- 2019.12.09 (Цаг үеийн асуудлаар)
- 2019.12.09 (Сарын төлөвлөгөө батлах, биелэлт хэлэлцэх)

Хурал бүрийн дараа хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулж, хурлын тэмдэглэлийг хөтөлж, ABLE цахим оффис дээр тухайн сарын батлагдсан төлөвлөгөөг байршуулж ажилласан.

### **5.2.3 Сар, жилийн ажлын төлөвлөгөө тайлан гарган, цахим хуудаст байршуулах**

Комисс сар бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг ажлын албаны ажилтнууд болон хэлтсийн дарга нараас авч, жилийн төлөвлөгөөн дээрээ үндэслэн боловсруулж, Комиссын хурлаар хэлэлцэж баталсаны дараа Авле программын олон нийтийн файлын санд байршуулж байна.

### **5.2.4 Үйл ажиллагааны сар, жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх**

Хэлтсийн дарга нараас болон ОНА-аас ирүүлсэн тайланг нэгтгэн Ажлын албаны дарга сар бүрийн Комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг гарган ажиллаж байна.

### **5.2.5 Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлан гаргах, цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулах**

Комиссын 2018 оны 12-р сар, 2019 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв. Комиссын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс мэдээллийн самбарт тухайн бүр төсвийн гүйцэтгэлийн

тайланг байрлууллаа. 2018 оны санхүүгийн баримтуудыг цэгцэлж үдэж архивт хүлээлгэж өгөв.

Мөн Сангийн яамтай тооцоо нийлж 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийв. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн яамны цахим системд шивж оруулсан. 2018 оны нэмэлт санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг санхүүжүүлэгч бүрээр гаргаж дуусав. Мөн өмнөх оны төслийн үлдэгдэл санхүүжилтийг дансандаа буцаан авч, зарцуулах эрх нээлгэж, холбогдох гүйлгээнүүдийг хийж, зарцуулж дуусган тайланг санхүүжүүлэгчид хүргүүлэв. Швейцарийн Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хүн амын сан болон Хөгжлийн хөтөлбөрийн 2018 оны санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг, санхүүгийн баримтын хуулбарын хамт хүргүүлэв.

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний Аудитын газар хүргүүлсэн. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын газраас аудит хийлгүй итгэмжлэл олгосон болно. НҮБ-ын Хүн амын сан болон Хөгжлийн хөтөлбөрийн 2019 оны санхүүжилтийг хүлээн авч дотоод томилолтын нарийвчилсан төсвийн хийж батлуулан холбогдох гүйлгээнүүдийг тухай бүрт нь хийв. ХХОАТ-ын 2019 оны 1,2,3,4-р улирлын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв.

#### ***5.2.6 Санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн зохион байгуулах, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих***

Эд хөрөнгийн 2018 оны жилийн эцсийн тооллого хийж, актлах шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гаргав. Комиссын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтөлж, мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Дотоод сүлжээ, компьютер, хэвлэх төхөөрөмжүүдэд гарсан гэмтэл доголдолуудыг цаг тухай бүр нь засч тохируулан хэвийн ажиллагаанд нь оруулж ажиллав.

#### ***5.2.7 Архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөх, Able программд байршуулах***

2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар Комисс нийт 657 албан бичиг, иргэдийн 617 гомдлыг хүлээн авсан байна. Эдгээрийг зохих журмын дагуу цахим болон журналаар бүртгэн танилцуулж шийдвэрлэлтийн үр дүнг эргэн мэдээлэх ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Комиссоос 2019 онд нийт 770 албан бичиг, 57 зөвлөмж, 39 шаардлагыг холбогдох байгууллага, иргэдэд зохих журмын дагуу хүргүүлж, Удирдлагын цахим программын файлын санд байршуулсан.

2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар Комиссын ажилтнуудад архивын баримтыг - 50 удаа түр ашиглуулж, хэвлэмэл хуудас - 2944 ширхэгийг дугаарлан, хуулбар үнэн болох тухай тэмдэг - 75 ширхэгийг дарж баталгаажуулсан.

#### ***5.2.8 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлан гаргах***

Шилэн дансны нэгдсэн цахим хуудагт Комиссын төсвийн 2018 оны 12-р сар, 2019 оны 1-ээс 12 дугаар сарын мэдээллийг оруулсан. 2018 оны 4-р улирлын болон жилийн эцсийн оруулах шаардлагатай мэдээллийг нэмж оруулав. Мөн 2019 оны урьдчилан оруулах шаардлагатай мэдээллүүд болон 1-12 дугаар сарын мэдээлэл, 1,2,3,4-р улирлын болон хагас жилийн оруулах шаардлагатай мэдээллийг нэмж

оруулав. Сарын мэдээллийг тухай бүр нь байгууллагын гаднах мэдээллийн самбарт хэвлэж тавив.

### **5.2.9 Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргах**

Уг ажлыг 2 сард ТАЗ-аас тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн болно. Мөн ТАЗ-ын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 255 дугаар албан бичгийн дагуу төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн мэдээллийн санг тогтмол хөтөлж байна. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргадаг цахим сан нь одоо шууд сангийн яамтай холбогдсон тул цалин болон холбогдох нэмэгдлүүдийг дахин хянаж оруулж байна.

### **5.2.10 Ажилтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх тайланг боловсруулан АТГ-т хүргүүлэх**

Энэ ажлын хүрээнд дарга, гишүүдийн мэдүүлгийг өөрийн биеэр АТГ-т хүргэж өгч, ажлын албаны 38 ажилтны ХОМ-ийг цаг хугацаанд нь мэдүүлэх тал дээр чиглэл өгч ажилласан. ХОМ-ыг бөглүүлж, бүртгэж дууссаны дараа АТГ-т тогтмол гаргадаг ХАСХОМ 1 Тайланг гаргаж, 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр АТГ-т албан бичгээр хүргүүлэв. Мөн 2019 оны хүрээнд 2 ажилтан их хэмжээний хөрөнгө орлогийн өөрчлөлт орсон гэсэн шалтгаанаар ХОМ дахин бөглөв.

### **5.2.11 Ажилтнуудын хувийн хэрэг бүрдүүлэлтийг хөтлөх, ажлын бичиг баримт, тодорхойлолт гаргах**

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан бүх ажилтнуудын хувийн хэргийг шинээр бүрдүүлж, шинэ маягтын дагуу анкет болон намтрыг бичүүлж авав. 2019 оны 12 дугаар сарын 17-ны байдлаар нийт 45 албан бичиг боловсруулж, явуулснаас банк болон бусад байгууллагуудад хандсан тодорхойлолт 22, бусад мэдээлэл өгөх, шагналд тодорхойлох албан бичгүүдийг боловсруулсан байна. Мөн Комисст 2019 оны байдлаар Говь-Алтай болон Орхон аймаг дахь орон нутгийн ажилтны сул орон тоо гарсан байна. Сул орон тоо гарсан талаарх мэдээллийг тухай бүр хуулийн хугацаанд Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн болно. Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэгт багтан ажиллаж, Комиссын төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг дахин боловсруулж, ТАЗ-д батлах зөвшөөрөл хүсэн илгээгээд байна. Одоогоор батлах эцсийн шатандаа явж байна.

Бүтэн жилийн хугацаанд Комиссын даргын тушаалууд А/13, Б/13, Ажлын албаны даргын А/17, Б/47 хүртэл дугаарласнаар батлагдсан байх бөгөөд төслийг боловсруулж, хянаж, батлуулсан байна. Мөн Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр, сургалт хөгжлийн хөтөлбөр болон 2019 оны сургалтын төлөвлөгөө, шагналын журмуудыг шинэ хууль, журамд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулан Абле цахим оффист байршуулав. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр төрийн албан хэрэг хөтлөлтийн үзлэгт 93 хувиар үнэлэгдсэн байна.

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИС**

